

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
НОМЫН САН
THE NATIONAL LIBRARY OF MONGOLIA

# НИЙТИЙН НОМЫН САНГУУДЫН ТАЙЛАН 2024(5)

УЛААНБААТАР ХОТ

2025 он

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
НОМЫН САН
THE NATIONAL LIBRARY OF MONGOLIA

# НИЙТИЙН НОМЫН САНГУУДЫН ТАЙЛАН 2024(5)

*(Тайлангийн эмхэтгэл)*

УЛААНБААТАР ХОТ

2025 он

ННА 78
DDC 020
Н 615

# Нийтийн номын сангуудын тайлан 2024(5)

---

Эмхэтгэсэн: Б.Сарандэлгэр /Арга зүйч/

Хянасан: Т.Хайдав /МАЗЭШХ-ийн дарга/

**ISBN 978-9919-9114-7-8**

**ГАРЧИГ**

ГАРЧИГ....................................................................................................................04

ӨМНӨХ ҮГ ..........................................................................................................05

ТӨВ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН....................................................................................................................06

УВС АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН....................................................................................................................27

ХОВД АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН....................................................................................................................66

ХӨВСГӨЛ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН...............................................................................117

ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН...............................................................................164

ХАВСРАЛТ............................................................................................................186

ДҮГНЭЛТ..............................................................................................................202

# ӨМНӨХ ҮГ

Технологийн хөгжилт, мэдээллийн хязгааргүй өсөлтийн энэ үед ард иргэдийг соён гэгээрүүлэгч, номын сан, мэдээллийн байгууллагын хэрэгцээ шаардлага улам ихээр бий болж байна. Дээрх өсөлтүүд нь номын сангуудыг соёл, боловсролын шинэлэг хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхийг зүй ёсоор шаардаж байна. Энэ шаардлагад нийцэх, хүрч ажиллахын тулд аймаг, нийслэлийн номын сангууд бүхий л талаараа хичээнгүйлэн ажиллаж ирсний илрэл, ул мөрийг энэхүү тайлангаас үзэх болно. Өмнөх жилүүдэд тус тайлан 300-600 хуудас болдог байсан бол энэ жил 800 гаруй хуудастай болж байгаа нь үүнийг илтгэх нэгэн сэжим болно. Өдий хэмжээний хуудастай номыг цахим файлд хөрвүүлэн уншихад ачаалал өгөх тул 200 хуудсаар нь салган 5 боть болгон нийтлүүллээ.

Өнгөрөгч 2024 он Монголын номын сангийн салбарт олон чухал, түүхэн үйл явдал болж өнгөрсний нэг нь Монгол Улсын Үндэсний номын сангийн салбар шинэ салбар ашиглалтад орж, номын санч- мэдээллийн ажилтнуудын сүүлийн 30 гаруй жилийн мөрөөдөл биелж, Монгол Улсын Соёлын яам, Монгол Улсын Үндэсний номын сан хамтран номын сангийн нэгдсэн системийг хөгжүүлэн, ашиглалтад хүлээн авснаар, аймаг орон нутгийн номын сангуудыг нэгдсэн системд холбон, албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг 21 аймгийн 216 номын санч мэдээллийн ажилтнуудад зохион байгууллаа. Энэ нь ном зүйн мэдээллийг автоматжуулж, үйл ажиллагаандаа орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, электрон мэдээллийн нэгдсэн санг бий болгох, хүртээмж нэмэгдүүлэхэд бодит хувь нэмрийг оруулсан явдал мөн.

Эмхэтгэлийн төгсгөлд уламжлал ёсоор аймаг, нийслэлийн нийтийн номын сангуудын үйл ажиллагааны статистикийн зарим үзүүлэлтүүдийг хүснэгтээр хавсаргалаа.

Эдгээр мэдээллүүд номын сангуудыг үйл ажиллагааг эрчимжүүлэх, сайжруулахад нэмэр болно гэдэгт итгэлтэй байна. Тайлантай холбоотой санал, хүсэлтээ манай номын сангийн lavlagaanomzui@gmail.com хаягаар болон 70188882 утсаар ирүүлнэ үү.

**МЭДЭЭЛЭЛ, АРГА ЗҮЙ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**

**ТӨВ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН**
**2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

## АГУУЛГА


1. **Номын сангийн мэдээлэл**
   - 1.1. Эрхэм зорилго
   - 1.2. Номын сангийн ерөнхий мэдээлэл
2. **Сан хөмрөг**
   - 2.1. Сан хөмрөгийн баяжилт
   - 2.2. Сан хөмрөгийн  хадгалалт хамгаалалт
3. **Үйлчилгээ**
   - 3.1. Уншлага, үйлчилгээ
   - 3.2. Зөөврийн номын сангийн үйлчилгээ
   - 3.3. Цахим номын үйлчилгээ
   - 3.4. Номын үзэсгэлэн
   - 3.5. Зугаатай зуны хөгжилтэй уншлага
   - 3.6. Номын хэлэлцүүлэг
   - 3.7. Зохиолч уншигчдын уулзалт
   - 3.8. Лавлагаа мэдээлэл
   - 3.9. Мэргэжил арга зүйн ажил
4. Соёл олон нийтийн ажил

5.Байгууллагын аюулгүй байдал
6. Гадаад харилцаа
7. Төсөл хөтөлбөр
8. Сургалт, семинар
9. Дугуйлан, Ногоон байгууламж
10. Хөрөнгө оруулалт, Төсөв
11. Монгол бичгийн албан хэрэг хөтлөлт
12.Бусад ажил


Тайлбар:

Төв аймгийн нийтийн номын сангийн 2024 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг 11 бүлэгт хуваан тайлагналаа.

## НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

**1.1. Эрхэм зорилго:** Мэдлэг оюунд тулгуурласан мэдээллийн эрин зуунд дэвшилтэд техник технологийг ашиглан уншигч, үйлчлүүлэгчдэд хэрэгцээт мэдээллийг нээлттэй хүргэх, Д.Нацагдоржийн нэрэмжит аймгийн нийтийн номын санг "Хүний хөгжил-цахим мэдээллийн төв" болгоно.

**1.2. Номын сангийн ерөнхий мэдээлэл:** Төв аймгийн Нийтийн номын сан нь анх 1944 оны 4-р сарын 28-нд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 54 дүгээр тогтоолоор олон түмэнд ном хэвлэлээр үйлчлэх үйл ажиллагаагаа эхэлж байсан бол 1989 оны 8-р сарын 1-нд нэг ээлжиндээ 120 хүн хүлээн авах, 100.000 ном байрлуулах хүчин чадалтай зориулалтын байранд шилжин орж үйл ажиллагаагаа явуулж байна. 2016 онд Д.Нацагдоржийн нэрэмжит аймгийн нийтийн номын сан болсон. Төв аймаг, БНСУ-ын Пёнтек хотын харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд 2020 онд Пёнтек хотоос 920 сая, ОНТ-өөс 276 сая нийт 1 тэрбум 196 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар засвар шинэчлэл хийгдэн уншигч, үйлчлүүлэгчид мэдээллээ чөлөөтэй олж авах чөлөөт сонголт бий болгож, тав тухтай орчин бүрдүүлж номын сангийн үйл ажиллагааг 1 дахин нэмэгдүүлж 238 хүний суудалтай болгон өргөжүүлсэн. Орон тооны нийт 13 ажилтан, албан хаагчтай үйл ажиллагаагаа явуулж байна.

**Нийтийн номын сан нь:**

- Захирлын өрөө
- Сургалтын танхим
- Лавлагаа мэдээллийн танхим
- Тогтмол хэвлэл
- Насанд хүрэгчдийн уншлагын танхим
- Цахим мэдээллийн танхим
- Нягтлан бодогчийн өрөө
- Архивын өрөө
- Хүүхдийн уншлагын танхим
- Гэрээр олгох танхим
- Цайны өрөө

**Цахим хаяг:** "Төв Нийтийн номын сан" – Фейсбүүк хаяг Library.to.gov.mn – Вэб сайт

**Цагийн хуваарь:** Даваа - Бямба гаригт 9:00 - 13:00, 14:00-18:00 цаг, /13:00 – 14:00 цайны цаг/

**Байгууллагын утас:** 77682770

**Номын сангийн захирал:** Т.Тунсаг

## ХОЁР. САН ХӨМРӨГ

**2.1. Сан хөмрөгийн баяжилт:** Уншигчдын эрэлт хэрэгцээг үндэслэн татгалзлалын дэвтэр хөтөлж тухайн жилийн батлагдсан төсвөөс сан хөмрөгийн баяжилтаа хийж ирсэн. 2024 оны жилийн эцсийн байдлаар төсвийн хөрөнгөөр 3,773,695 төгрөгийн 155ш ном, Хандив тусламжаар 2,163,000 төгрөгийн 52ш ном нийт 4,857,395 төгрөгний 168ш номоор сан хөмрөгөө баяжуулан электрон каталогт оруулан уншигчдын хүртээл болголоо.

**2.2. Сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт:** Номын сангийн чухал зүйлийн нэг бол сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт байдаг. Ийм учраас 2024 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Уншлагын танхимуудын сан хөмрөгийн урагдаж гэмтсэн, шаардлага хангахгүй болсон 145 ширхэг номыг өөрсдийн нөөц бололцоог ашиглан сэлбэн засаж, уншлага үйлчилгээнд гаргасан.

2. Сан хөмрөгт хадгалагдаж байгаа нийт ном, хэвлэл болон тавиурын тоосыг арчиж цэвэрлэсэн.

3. Байгууллагын өрөө тасалгаануудад жилд 4 удаа цэвэрлэгээ, ариутгал хийлгэсэн.

4. Шинээр ирсэн 168 ширхэг номыг бүртгэж, 3 танхимдаа хуваарилан танхим тус бүр техник ажиллагаагаа хийж ШУ–ны салбаруудаар тавиурт байрлуулсан.

5. Улирал бүр “Номын санч сэтгүүл” , ”Улирал ба зохиолч” , ”Төрийн мэдээлэл”, “Уламжлал” гэсэн 4 нэр төрлийн 195 ширхэг сэтгүүл захиалж уншигчдад хүргэж хаягжуулж, тогтмол хэвлэлийн фондод байршуулсан.

6. “Өдрийн сонин” , ”Зууны мэдээ” , ”Хүмүүн бичиг” , ”Утга зохиол урлаг” гэсэн 4 төрлийн сонинг захиалан уншигч үйлчлүүлэгчдэд хүргэсэн. “Өдрийн сонин”, ”Зууны мэдээ” сонины 249 дугаарыг сар сараар нь багцлан үдэж, ”Хүмүүн бичиг” сонины 42 дугаарыг багцлан үдэж тус бүр хаягжуулан архивласан.

7. Номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж буй “Анхдугаар таван жил” сонины 1961 оноос 1990 он хүртэлх дугааруудыг хавтаслаж үдэн хадгалалт хамгаалалтыг сайжруулсан. Мөн Байгууллагын www.library.to.gov.mn Вэб сайтад 1963, 1964, 1965, 1966 оны 176 дугаарыг цахимд оруулан уншигчийн хүртээл болгосон.

## ГУРАВ. ҮЙЛЧИЛГЭЭ

Нийтийн номын сан нь Насанд хүрэгчдийн уншлагын танхим, Хүүхдийн уншлагын танхим, Гэрээр олгох танхим гэсэн 3 танхимаар иргэд, уншичдад үйлчилж 2897 байнгын уншигч, 13633 ирэгсэд, 35323 ном, 201 сэтгүүл, 520 сонингоор танхимаар болон гэрээр олгож үйлчилгээ үзүүлсэн.

**3.1. Уншлага, үйлчилгээ:** Уншлага үйлчилгээг дараах байдлаар тус тус хүргэсэн байна.

1. Насанд хүрэгчдийн уншлагын танхим: 1049 байнгын уншигч, 4381 ирэгсэд, 10226 ном танхимаар болон гэрээр олгосон.

2. Хүүхдийн уншлагын танхим: 1031 байнгын уншигч, 4689 ирэгсэд, 13252 ширхэг ном танхимаар олгосон.

3. Гэрээр олгох танхим: 817 байнгын уншигч, 4563 ирэгсэд, 11845 ширхэг ном танхимаар болон гэрээх олгосон.

**3.2. Зөөврийн номын сангийн үйлчилгээ:** Аймгийн нийтийн номын сан нь Зөөврийн номын сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хөдөө орон нутгийн иргэд,

уншигч, үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх, цар хүрээг өргөжүүлэх, мөн шинэ номын танилцуулга хийх зорилготойгоор Баянхангай, Эрдэнэсант, Лүн, Өндөрширээт, Баянцогт, Баянхангай, Дэлгэрхаан, Бүрэн, Өндөрширээт, Эрдэнэ, Эрдэнэсант, Архуст, Сэргэлэн, Баянчандмань, Зуунмод сумын 6-н баг, МСҮТ, УБЦТС-Зуунмод ХҮГ, Нархан хүүхэд хөгжлийн төв, Ахмадын сувилал, ХЦА Сургуулийн Б дотуур байр, ХЦБ Сургуулийн 3б ангийн багш, 016-р цэргийн анги гэсэн байгууллагуудын сургуулийн номын санч нартай хамтран 1-3 сарын хугацаатайгаар “Зөөврийн номын сан”-ийн үйлчилгээг хүргэсэн. Нийт 15 сум, 8 байгууллагын **1757** иргэнд **2700** номыг олгож уншуулсан.





**3.3. Цахим номын үйлчилгээ:** 1. Байгууллагын цахим хуудсанд электрон каталогоо байрлуулан иргэд, уншигчид орон зай харгалзахгүйгээр **14134** төрлийн **36060** номын мэдээллийг авах боломж бүрдсэн. Мөн байгууллагын Facebook цахим хуудсанд видео мэдээлэл 48, цахим ном 168, хүүхдийн уншлагын танхимаас 52 үлгэр, хөгжөөнт бодлого 41, танин мэдэхүй 60 нийт **323** мэдээ мэдээллийг бэлтгэн байршуулж **151260** иргэн хандалтаар орж мэдээлэл авсан. Цахим мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор цахим сайтад 35 удаагийн цахим номын үзэсгэлэнг гарган 6890 уншигч, үйлчлүүлэгч зочилж мэдээлэл авсан.











### 3.4. Номын үзэсгэлэн:

**1.** 2024 онд Нийтийн номын сангийн сан хөмрөгийн төрөл анги болон уран зохиолын номоор шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 24 удаа зохион байгууллаа. “Үндсэн хууль тусгаар тогтнол”, “Бидний эх хэл”, “Монголын гуа хатад”, “Эх орны эзэд”, “Номтой нөхөрлөе”, “Дэлхийн шилдэг зохиолууд”, “Ханс Кристион Андерсений зохиол”, “Үндэсний бичиг соёл”, Монгол ёс заншил” “Хамгийн хамгийн” “Бидний ирээдүй гэрэлтэй сайхан”, “Монгол наадам”, “Эх хэл бидний бахархал”, “Сурагчдын заавал унших зохиол” “Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт зохиолчдын номын үзэсгэлэн” “Монгол бичиг-ёс заншил, бийрэн бичлэг” зэрэг сэдэвчилсэн 20, шинэ номын 4 удаагийн үзэсгэлэнг 720 номоор гаргаж 5800 уншигч иргэдэд хүргэсэн.



- **2.** Нийтийн номын сан үүсэн байгуулагдсан түүхт 80 жилийн ойн хүрээнд






**“Мөнхөд орших номын хэлхээ”** сэдэвт номын үзэсгэлэнг номын санд дэлгэн гаргаж нийт 300-аад хүн үзэж сонирхсон байна.

**3.5. Зугаатай зуны 100 хөгжилтэй уншлага:** Нийтийн номын сан нь Зуунмод сумын 6 багтай хамтран "ЗУГААТАЙ ЗУНЫ ЗУУН ХӨГЖИЛТЭЙ УНШЛАГА" арга хэмжээг хүүхэд багачуудын дунд амжилттай зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд “Номын уншлага” хийж Үлгэрийн ном,

Оюун ухаан, Танин мэдэхүй, Адал явдалт номуудыг уншиж, дүгнэлт хийн утга санааг хамтран ярилцлаа. Уншигч хүүхдүүддээ зориулан Шанага долоон одны домог, Үнэг Тогоруу хоёр, Ухаантай хүү, Алтан Шувуу, Нэг төө өвгөн, Нугасны муухай дэгдээхэй, Худалч гүнж зэрэг үлгэрүүдийг дэлгэцээр үзүүлж, үлгэрээс авах сургамж, эерэг ба эсрэг дүрүүдийн тухай харилцан ярилцсан. Мөн “АХА” тэмцээн, эвлүүлдэг “PUZZLE” зэрэг тоглоомуудыг хүүхдүүдийн дунд зохион байгуулахад мэдлэг оюунаа уралдуулан баг хамт олноороо идэвхтэй оролцож байлаа. Арга хэмжээнд оролцсон насанд хүрэгчид болон хүүхдүүдэд номын сангийн уншигчийн картыг үнэгүй нээсэн. Нийт 500-аад уншигч хүүхэд багачуудыг хамруулаад байна.








**3.6. Номын хэлэлцүүлэг:** Нийтийн номын сангийн дэргэдэх “Ертөнц” номын клубыг ХЦАСургуулийн 10-12-р ангийн 11 сурагч хамрагдан байгуулсан. Нийтийн номын сангийн Гэрээр олгох танхимаас ЕБСургуулийн ахлах ангийн 11 сурагчдад (эр-3, эм-8) "Цойлогсод" номоор номын хэлэлцүүлгийг хийлээ. Хэлэлцүүлгийн гол зорилго нь: Еврейчүүдийн амжилт, сэтгэл зүй, зуршил, хүмүүнлэгийн гайхамшигт нууцаас танин мэдэж хамтран ярилцах, санал бодлоо солилцоход оршиж байсан бол Хэлэлцүүлэгийн дүгнэлтээс хүүхдүүд "Мөрөөдөл чамайг гараанаас гарахад тусална, Харин дадал зуршил чинь л гагцхүү чамайг хаа хүрэхийг шийдэх болно." гэсэн ишлэлээс Физиологийн хувьд бид Еврей хүн байж чадахгүй ч сэтгэлгээ, сахилга бат, дадал, тууштай байх чанаруудыг эрхэмлэх нь чухал гэдгийг ойлгож авсан. Нийтийн номын сангийн дэргэдэх "Ертөнц" номын клубээс Номын баяр-2024 арга хэмжээнд ХЦДС-ийн 5 бүлгийн 140 сурагчдыг хамруулан Өгүүллэг сонсгож





хүүхэд бүрт төрсөн сэтгэгдэлийг нь зургаар илэрхийлэн хэлэлцүүлэг зохион байгуулсан.

### 3.7. Зохиолч уншигчдын уулзалт:

- Төв аймгийн Нийтийн номын сангийн түүхт 80 жилийн ойг тохиолдуулан “Зохиолч уншигчдын уулзалт”-ыг зохион байгуулан зочдоор Төв аймгийн Угтаалцайдам сумын уугуул Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт, Монголын Зохиолчдын эвлэлийн шагналт, хүүхдийн зохиолч Оюунбадамын Сундуй, Монголын Зохиолчдын эвлэлийн шагналт, Яруу найрагч, хүүхдийн зохиолч Чулуунбилэгийн Алтанхуяг нар оролцлоо.

  Уулзалтанд ном эрдмийг шимтэн уншдаг хүүхэд залуучууд хүрэлцэн ирж уран бүтээлийг нь шимтэн сонсож, хүсэл сонирхлыг нь төрүүлсэн халуун дотно яриа өрнүүлж, зохиолчид шүлэг яруу найргаасаа толилууллаа.






- Монголын Зохиолчдын эвлэлийн шагналт, Болор цомын эзэн, “Миний нутаг-2024” яруу найргийн наадмын тэргүүн байрын шагналт, яруу найрагч Норовын Гантулга оролцож, яруу найрагт дуртай, номыг шимтэн уншигч Зуунмод сумын ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд залуус, "Номын андууд" клубын сурагчидтай халуун дотно яриа өрнүүлэн, тэдний сонирхсон асуултад хариулт өгч соёлын боловсрол олголоо. Энэхүү арга хэмжээнд 150 /85эм,65эр/ хүүхэд багачууд, насанд хүрэгчид хамрагдлаа.




 

**3.8. Лавлагаа мэдээлэл: Л**авлагаа, номзүйн үйлчилгээг танхимаар 51, цахимаар 40 нийт 91 уншигч, үйлчлүүлэгч лавлагаа мэдээлэл авсан.

**3.9.Мэргэжил арга зүйн зөвлөгөө:** Аймгийн нийтийн номын сан нь 2024 онд Алтанбулаг, Лүн, Өндөрширээт, Баянхангай, Эрдэнэсант, сумдын соёлын төв болон ЕБС-ийн номын санч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэлээ. Сумдын номын сангийн үйл ажиллагаатай танилцан номын сангийн нэгдсэн бүртгэл, нэг бүрчилсэн бүртгэл болон өдөр тутмын бүртгэлийг хэрхэн хөтлөх, ном ангилах арга зүйн зөвлөгөөг 5 сумын 12 номын санчдад өглөө.

  

## ДӨРӨВ. СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ

- **4.1.** Төв аймгийн Нийтийн номын сангийн түүхт 80 жилийн ойг тохиолдуулан "УХААРЛААС УРГАСАН БОДОЛ" яруу найргийн уралдаан нь 2 үе шаттай зохион байгуулсан.Тус арга хэмжээнд хүндэт зочноор Төв аймгийн Угтаалцайдам сумын уугуул Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт, Монголын Зохиолчдын эвлэлийн шагналт, хүүхдийн зохиолч Оюунбадамын Сундуй, Монголын Зохиолчдын эвлэлийн шагналт, Яруу найрагч, хүүхдийн зохиолч Чулуунбилэгийн Алтанхуяг нар шүүгчээр оролцлоо. Арга хэмжээний 1-р шатанд 18 сумын 67 шүлэг, яруу найраг сонирхдог хүүхдүүд оролцож 2-р шатанд 20 хүүхэд шалгарч эхний 3 байр шагнагдлаа.












- **4.2.** Олон улсын гэр бүлийн өдөр #ГЭР БҮЛДЭЭ-ГЭРЭЛ НЭМЬЕ_аяны хүрээнд Төв аймгийн Нийтийн номын сангаас дараах арга хэмжээг ажилтан албан хаагчдынхаа хүүхдүүд болон танхимд ирсэн уншигч хүүхдүүдэд амжилттай зохион явууллаа.

  - Хөгжөөнт тоглоом
  - Оньсого таалцах
  - Бидний хамгийн тухтай, тавтай, тайван орчин номын сан нэртэй хэлэлцүүлэг хийлээ.





- **4.3.** Монгол Улсын урт хугацааны “Алсын хараа-2050” хөгжлийн бодлогын хүрээнд, Монгол Улсын ерөнхийлөгчийн 2012 оны 158-р зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор “**ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН БАЯРЫН ӨДРИЙГ**” уламжлалт зан заншлаа хөгжүүлж, ард иргэд хүүхэд залуусын ном эрдэмд гэгээрэн нөхөрлөх хандлагыг улам бүр дэмжих иргэд уншигч, хүүхэд залуучуудыг номтой нөхөрлүүлэх, тэдний авъяас чадварыг нээн хөгжүүлэх, зөв хүн болгон төлөвшүүлэх, үндэсний бичиг соёлыг сурталчилах зорилгоор 35,36 дахь удаагаа “**ИЛҮҮ ИХ УНШЪЯ** ” уриан дор, Төв аймаг нийтийн номын сан үүсэн байгуулагдсаны түүхт 80 жилийн ойг угтан 10*8 хөтөлбөрийн хүрээнд зохион байгууллаа. Уг арга хэмжээнг 05 дугаар сарын 16-17-ний өдөр

нийтийн номын сан, мөнх алдарын талбайд тэмдэглэж, нийт 2100 /1200эм, 900эр/ гаруй иргэд, хөдөлмөрчид, хүүхэд залуус оролцлоо.

Тус арга хэмжээний нээлтэнд Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Ц.Жамбалсүрэн, Аймгийн Засаг даргын НБХ-ийн дарга Д.Мөнхцэцэг, Соёл, урлагийн газрын дарга Б.Тунгалаг, Нийтийн номын сангийн захирал Б.Зоригтбаатар, Музейн захирал Н.Мөнхсайхан, Монгол туургатан театрын захирал Д.Намсрайноров, Зуунмод сумын Соёлын төвийн дарга Ш.Батмөнх болон Зуунмод сумын ЕБС-ийн сурагчид, төрийн албан хаагчид, ард иргэд оролцлоо. Үндэсний бичиг соёл, номын баярыг угтан, хүүхэд бүр уншигч хөтөлбөрийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд номын сайн нөхөр “Өглөөний уншлага” аяныг зарлаж 11 сумын Ерөнхий боловсролын сургуулийн 50 ангийн 1500 /850 эм, 650 эр/хүүхэд хамрагдлаа. Шилдэг уншигч анги хамт олноор:

- Төв аймгийн Аргалант сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийн Лхам багштай 8а анги
- Зуунмод сумын Монгени 5-р сургуулийн Мөнхбаяр багштай 7а анги
- Төв аймгийн Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн Алтангэрэл багштай 1б анги
- Зуунмод сумын Монгени 5-р сургуулийн С.Энхтуяа багштай 4в анги
- Зуунмод сумын Монгени 5-р сургуулийн 5а ангийн сурагч Мөнхжаргалын Энхдөлгөөн нар шалгарлаа.












- **4.4.** Бяцхан хүүхэд багачуудыг “Үлгэрээр хүмүүжүүлье” уриатайгаар номд дурлуулах, номтой нөхөрлөхийн үнэ цэнэ, ач холбогдлыг таниулах, хүүхдийн ном унших сонирхлыг төрүүлэх зорилгоор “Хүүхдийн уншлагын танхим”-с **“КИНО ӨДӨР”** арга хэмжээг зохион байгуулан нийт 24 удаагийн үлгэрээр **485** хүүхэд багачуудыг үлгэрийн ертөнцөөр аялуулж, кино зохиолын ялгааг таниулсан.






- **4.5.** Их зохиолч Д.Нацагдоржийн нэрэмжит Нийтийн номын сангийн түүхт 80 жилийн ойг тохиолдуулан "Гадаад харилцаа-Хамтын ажиллагаа" сарын аяны хүрээнд "АНИМЭ гар зургийн уралдаан", "Миний мэдэх Солонгос Улс" эссэ бичлэгийн уралдаан нийт 80 гаруй хүүхэд, насанд хүрэгчид оролцон зохион байгуулагдлаа.

  

 

- **4.6.** “Соёлын бүтээлч сар" аян хүрээнд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Их эзэн чингис хааны мэндэлсэн өдөр буюу Монгол бахархлын өдөрт зориулан "ӨВ СОЁЛОО ЭРХЭМЛЭН ДЭЭДЭЛЬЕ" монгол уламжлалт тоглоом наадгай тэмцээнийг зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээнд 5 байгууллагын 45 /31эм,14эр/ албан хаагч оролцлоо.

 





- **4.7.**“Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд, Орчин үеийн утга зохиолыг үндэслэгч Төв аймгийн уугуул Д.Нацагдоржийн мэндэлсний 118 жилийн ойг угтаж албан байгууллага, иргэд хүүхэд өсвөр үеийнхнийг номтой нөхөрлүүлэх, зохиолчдын уран бүтээлийг уншигчдад сурталчлах, эх хэлний зөв хэрэглээг хэвшүүлэх, хэл яриаг хөгжүүлэх, зохиолын баатрын дүрд хувиран жүжиглэх, сайн муүг ялган хүүхэд багачуудад үлгэр дуурайлал болгох, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “ЗОХИОЛ АМИЛСАН НЬ” дүрийн тоглолтыг жил бүр уламжлал болгон зохион байгуулж байна. Энэхүү арга хэмжээнд ЕБС-ийн 7 баг, насанд хүрэгчдийн 2 баг нийт 310 /190эм,120эр/ хүүхэд, насанд хүрэгчид хамрагдсан.









- **4.8. "Соёлын бүтээлч сар"** аяны хүрээнд "Монгол өв соёлоо эрхэмлэн дээдлэе" номын болон оньсон тоглоом наадгайн үзэсгэлэн, Их зохиолч Д.Нацагдорж болон төв аймгаас төрөн гарсан ардын 5 уран зохиолчдын бүтээлийн номын үзэсгэлэнг гаргасан.





- **4.9.** 2024 оны "Хилэнт эх" хэмээх Модон луу жилийн цагаан сарын баярыг тохиолдуулан "Монгол уламжлалт өв соёл" арга хэмжээний хүрээнд:
    - Монгол бахархал
    - Монгол үндэсний дээл
    - Морин хуур хөгжмийн талаар хэлэлцүүлэг зохион байгууллаа.

  Мөн арга хэмжээнд хүүхэд, багачууд хүрэлцэн ирж морь уралдуулах, алга





мэлхий өрөх, шагай шүүрэх зэрэг өв уламжлалт тоглоом наадгайгаар тоглон номын үзэсгэлэнтэй танилцан, Цагаан сарын ёс заншлаас мэдэж авлаа.Нийт 94 хүүхэд багачууд хамардсан./ эмэгтэй 51, эрэгтэй 43/





- **5.0.** "Байгууллагаараа номтой нөхөрлөе" өдөрлөгт Төв аймгийн цагдаагийн газрын албан хаагчид хамрагдаж, байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, санал бодлоо солилцон, үндэсний бичиг үсгээ, сурталчилах зорилгоор "Алтан

үсэг" тэмцээнийг амжилттай зохион байгуулаж 65 / 51эр, 14эм/ албан хаагчид хамрагдлаа.






- **5.1.** Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн иргэд, хүүхдүүдэд Нийтийн номын сангийн үйл ажиллагаа, үйлчилгээг танилцуулах зорилгоор **“Төв Аймаг, Пара-хөнгөн”** атлетикийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн”-ны үеэр номын сангийн уншлагын танхимуудаас тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн 50 хүүхэд болон насанд хүрэгчидэд нийт 150 ш үнэгүй карт нээж 375 номоор зөөврийн үйлчилгээ үзүүлж, 58 ширхэг номын хандив өргөлөө. Мөн тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн иргэдийг байгууллагын үйл ажиллагаатай танилцуулж, иргэдэд өөрсдийн саналаар Сонсдог ном, 45ш номоор зөөврийн номын үйлчилгээ хүргэсэн.

  - **“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БА ТЭГШ ХҮРТЭЭМЖ**” чуулга уулзалтыг цахим, танхим хослуулан цахимаар 238 иргэн, танхимаар 76 иргэн оролцонд нийтийн номын сангийн "Хүүхдийн уншлагын танхим"-с шинэ номын танилцуулга, хүүхдүүдийн бүтээлийн үзэсгэлэнг дэлгэн гаргаж, Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн нийт-37 иргэдэд уншигчийн картыг үнэгүй нээж, 41 номоор зөөврийн номын үйлчилгээг хүргэсэн. Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн нийт 126 иргэдэд, 416ш номоор зөөврийн номын үйлчилгээг хүргэлээ.

  

 

- **5.2.** Их зохиолч Д.Нацагдоржийн нэрэмжит Нийтийн номын сангийн түүхт 80 жилийн ойг тохиолдуулан Зэвсэгт хүчний 119-р цэргийн ангитай хамтран хугацаат цэргийн алба хаагчдын дунд "Алтан үсэг" тэмцээн, “Номтой зочин”, "Ээждээ захидал бичээрэй" захидлын уралдааныг зохион байгууллаа.

  


  

## ТАВ. БАЙГУУЛЛАГЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Нийтийн номын сан нь 24 цагийн харуул хамгаалалт, галын дохиолол, гадна ба дотор хяналтын камер, гадна талбайн гэрэлтүүлэг зэргийг хийж аюулгүй байдлыг хангасан.Мөн үүдний хаалганд соронзон долгионоор мэдрэгч дохиолол бүхий хамгаалалтын төхөөрөмж байрлуулж ном алдагдахаас сэргийлсэн.

## ЗУРГАА. ГАДААД ХАРИЛЦАА

**6.1.**Япон улсын Тоттори мужийн номын сан болон Д. Нацагдоржийн нэрэмжит Төв аймгийн нийтийн номын сан хооронд адил тэгш байх зарчимд тулгуурлан 5 жилийн хугацаатай 20 ном солилцоо хийх үйл ажиллагааг эхлүүлж 2024оны 06 сарын 09 нд 20 номоо Тоттори мужийн номын санд илгээж тотори мужаас 12 сард ном солилцооны 20 ном ирж уншигч, үйлчлүүлэгчдийн хүртээл болгосон.











## ДОЛОО. ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

**7.1.** Нийтийн номын сан нь 2024 оны Улсын төсвөөс 100,000,000 төгрөгний тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг хүлээн авч үйл ажиллагаандаа хэрэглэж байна. Соёлын яамны үр дүнд суурилсан санхүүжилт, үйл ажиллагааны хөрөнгө оруулалтаар “багаар ажиллах өрөө”-г 13,600,000 төгрөгөөр бий болгон ажиллаж байна.



**7.2** "Цорж багш Давааням сан"-гаас номын санд сургалтын танхимыг 5,300,000 төгрөгөөрг байгуулсан.





**НАЙМ. СУРГАЛТ, СЕМИНАР**

**8.1**. Албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 17 удаагийн сургалтад албан хаагчдаа хамруулсан. Хамрагдсан сургалтуудыг жагсаавал: “Соёл ба хөгжил” сургалтад 8 албан хаагч, “Ахисан түвшний жендерийн дүн шинжилгээ”,“Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ үнэлгээ”-ний цахим сургалтад номын сангийн мэргэжлийн 7 албан хаагч хамрагдаж гэрчилгээ авсан. “Менежментийн чадавхыг бэхжүүлэх нь”, “Цахим сан хөмрөгийн зохион байгуулалт”, “Жендерийн мэдрэмжтэй харилцаа холбоо” цахим сургалтад 1 албан хаагч, “Залуучуудын чуулга” уулзалтад 3 албан хаагч, Төрийн архивын тасгаас зохион байгуулсан архив албан хэрэг хөтлөлтийн 2 удаагийн сургалтад 1 албан хаагч, Авлигатай тэмцэх газраас олон нийтийн авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх, үйл ажиллагаагаа танилцуулах зорилгоор “Таны эрх, таны оролцоо-авлигад үгүй гэж хэлье” сэдэвт сургалтад 1 албан хаагч, Зуунмод цэцэрлэгжүүлэлтийн газраас зохион байгуулсан “Мод ургуулах ашиг тус”, “Оффисын ногоон байгууламж” түргэвчилсэн сургалтад 2 албан хаагч, emongolia цахим систем сургалтад 2 албан хаагч, тоон гарын үсэг цахим шилжилт сургалтад 2 албан хаагч, Төрийн архивын тасаг, хэлний бодлогын зөвлөлөөс зохион байгуулсан “Цахим бичвэрийн сургалт”-д 1 албан хаагч, Онцгой байдлын газрын “Газар хөдлөлтийн аюул” сургалтад 6 албан хаагч, Цагдаагийн газрын “Гэр бүлийн харилцаа” сургалтад 7 албан хаагч, “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны хүрээнд “Нандин бүхнээ хамгаалъя” сургалтад 7 албан хаагч, Архив албан хэрэг хөтлөлт сургалтад 7 албан хаагч, төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 цахим сургалтад албан хаагчид 7 хоног бүр нийт 29 удаагийн танхим, 13 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 156 ажилтан албан хаагч хамрагдсан байна.






## ЕС. ДУГУЙЛАН, НОГООН БАЙГУУЛАМЖ

- **9.1** "Цахим танхим"-д "Компьютерын анхан шатны сургалт", “Зохист аялгуу” “Солонгос хэлний” дугуйлангууд хичээллэж байна.





- **9.2.** Нийтийн номын сангийн түүхт 80 жилийн ойн хүрээнд байгууллагын гадна талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэн олон наст үрийг суулган, гадна тохижилтыг албан хаагч нар хийсэн. Мөн албан хаагч бүр тасалгаанд цэцэг тарьж ургасан цэцгийг гадна тохижилтод 80ш цэцгийн мандал болгон байршуулан ажилласан.





## АРАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСӨВ

2024 оны байдлаар Улсын төсвийн санхүүжилтаар 373,179.620.4 төгрөгийн санхүүжилт орсноос 365,242.165 төгрөгийн гүйцэтгэлтэй. Мөн Орон нутгийн санхүүжилтаар 137,204.300 төгрөг орсноос 139,039.765 төгрөгийн зардал гарч байна. Шилэн дансны ил тод байдлыг ханган хуулийн хугацаанд мэдээллийг бүрэн гүйцэт байршуулан тухайн сарын 8-ны дотор тайлагнаж байна. Нийт 171 мэдээлэл байршуулахаас 171 мэдээлэл оруулсан.

## АРВАН НЭГ. МОНГОЛ БИЧГИЙН АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ

Төв аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөл, Төв аймгийн төрийн архивын тасаг, Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс зохион байгуулсан "Төрийн албан хэрэг хөтлөлтийг үндэсний монгол бичгээр хөтлөх ажлыг шат дараалалтай хэрэгжүүлнэ" гэж тусгасны дагуу 1. Байгууллагын гадна болон дотор хаяг, албан хаагчдын хувийн хэрэг, байгууллагын үйл ажиллагааны хавтсыг кирилл монгол бичгээр хослуулан хаягжуулан албан хэрэгцээнд хэрэглэж байна. 2. Номын сангийн 8 албан хаагчид кирилл, монгол бичиг хосолсон энгэрийн тэмдэгтэй болсон. Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаад нийт 13 албан хаагчаас 8 албан хаагч хамрагдаж гарааны үнэлгээгээ тогтоолгосон. Үүнээс 70-с дээш хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдэж гэрчилгээ авах болзол хангасан нэг албан хаагч сургалтаас чөлөөлөгдсөн. "Өв соёлоо эрхэмлэж үндэсний бичгээ сурцгаая 2025" аяны хүрээнд Эх хэлний өдрийг сар бүр тогтмол зохион байгуулж хэвшсэн. Үүний хүрээнд: Монгол бичгийн бататгал хичээл, Монгол тоо тоолол хичээлүүдийг тус тус явуулсан. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилт хангах хүрээнд Засгийн газрын 2022 оны 7 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2021 оны А246 дугаар захирамжийн заалтуудыг ажил болгон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд "Төрийн албан хэрэг хөтлөлтийг үндэсний монгол бичгээр хөтлөх ажлыг шат дараалалтайгаар хэрэгжүүлнэ" гэж тусгасны дагуу байгууллага, иргэдтэй харилцаж байгаа албан бичгийг Mongolia bati фонтыг ашиглан хос бичгээр хөтлөн хавсаргаад байна.





## АРВАН ХОЁР. БУСАД АЖИЛ:

1. Байгууллагын гадна талбайн хог хаягдлыг өдөр бүр цэвэрлэж, ажилтан, албан хаагч, уншигчдад тав тухтай, аюулгүй орчин бүрдүүлэн ажилладаг.





2. Бүх нийтийн их цэвэрлэгээг хамт олноороо хийж гүйцэтгэдэг

  

2.Байгууллагын ажилтан албан хаагчдыг хөдөлгөөниы дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Идэвхитэй хөдөлгөөн-Эрүүл мэнд” сургалт хөгжлийн цагийн төлөвлөгөөг боловсруулан үндсэн 3 чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулж байна.

 

 

........................ o O o .........................

# ЗАЯ БАНДИДА НАМХАЙЖАМЦЫН НЭРЭМЖИТ УВС АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

**Агуулга**


1. Номын сангийн алсын хараа, зорилго, зорилт
2. Номын сангийн сан хөмрөгийн бүрдүүлэлт, зохион байгуулалт, хадгалалт, хамгаалалт
3. Интернет үйлчилгээ
4. Номын сангийн уншлага үйлчилгээний зохион байгуулалт
5. Лавлагаа, номзүйн үйл ажиллагаа
6. Номын сангийн орон нутаг судлах үйл ажиллагааа
7. Номын сангийн мэдээлэл, технологийн үйл ажиллагаа
8. Арга зүйн үйл ажиллагаа
9. Зохиогдсон Соёл олон нийтийн ажил
10. Үзэсгэлэн
11. Хүний нөөцийн талаар
12. Төсөв санхүүгийн үйл ажиллагаа
13. Бусад


**<u>Үйл ажиллагаандаа баримтлан ажилладаг хууль, тогтоомж:</u>**

- МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО
- МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ТУХАЙ ХУУЛЬ
- СОЁЛЫН ӨВИЙН ТУХАЙ ХУУЛЬ
- НОМЫН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬ,
- ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН БУСАД ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРМУУД
- ЗАСГИЙН ГАЗРЫН БОДЛОГО, ЧИГЛЭЛ МӨРИЙН ХӨТӨЛБӨР
- АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛУУДЫГ ГОЛ ЗОРИЛГОО БОЛГОН АЖИЛЛАЛАА.

## Нэг. 1. Номын сангийн алсын хараа, зорилго, зорилт

**Алсын хараа: "**Ард иргэд оюуны өргөн мэдлэг, мэдээлэл олж авахад уламжлалт болон мэдээллийн технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ зөвлөн туслагч нь байна".

**Эрхэм зорилго:**

"Үйлчлүүлэгчдийнхээ оюуны эрэлт хэрэгцээг бүрэн дүүрэн хангаж чадахуйц хөгжлийн түвшинд хүрч, номын санг иргэдэд үйлчлэх "**Нээлттэй мэдээллийн төв**" болгоно.

## Номын сангийн талаарх ерөнхий мэдээлэл:

Манай номын сан нь аймгийн хамгийн анхны Нийтийн номын сан болж 1936 онд байгуулагдсан 80 гаруй жилийн түүхтэй байгууллага юм. Нийт 15 ажилтантай, уншлага үйлчилгээний 5 танхимтай, 20 гаруй шинжлэх ухааны 22705 нэр төрлийн 71906 ширхэг ном хэвлэлээр иргэдэд үйлчлэхээс гадна уншигч, үйлчлүүлэгч, иргэдийг ном уншигч, номын сангийн уншигч болгох зорилгоор Соёл танин мэдэхүйн олон төрлийн ажлыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.

Манай байгууллагын уншигчдад мэдээлэл хүргэх, хэлбэр нь:

Үндсэн үйлчилгээ

Вэб сайт: http://uvslibrary.blogspot.com , http://uvslibrary.weebly.com

Сошиал медиа: http://facebook.com/uvslib

Номын сангийн албан ёсны имэйл хаяг: libraryofuvs@gmail.com

**Ажиллах цагийн хуваарь:**

Даваа-Баасан гарагт Өглөө 8.00-20,00 цаг

Бямба, Ням гарагуудад Өглөө 10:00-17:00 цаг хүртэл ажилладаг.

Байгууллагын утасны дугаар: 70452477

## Хоёр. Номын сангийн сан хөмрөгийн бүрдүүлэлт, зохион байгуулалт, хадгалалт, хамгаалалт

Номын сангийн фондыг төсөв, бэлэг хандив, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр гэсэн олон төрлөөр бүрдүүлж ажилладаг. Номын баяжилтыг нийтийн номын сангийн чиглэлийн дагуу шинжлэх ухааны бүхий л төрлийн ном хэвлэлээр бүрдүүлдэг боловч уншигчдын эрэлт хүсэлт, лавлагаа татгалзлын бүртгэлийг харгалзан стандартын дагуу бүрдүүлж ажиллаж байна.

**Сан хөмрөгийн бүрдүүлэлт:**

Номы фондод тавигдах Монгол улсын стандарт MNS5742:2007 стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

- Стандартад заагдсанаар тавиур хоорондын зай, гэрэлтүүлэг, агааржуулалт, номын багтаамж зэргийг хангаж ажиллах, фондын хадгалалт хамгаалалтын стандартыг сайжруулахын тулд чийг дулаан хэмжигч багаж тавьж дулаан чийгийг тогтмол хэмжиж тэмдэглэл хөтөлж ажиллаж байна.
- Мөн мэргэжлийн байгууллагаар 1 удаа ариутгал, 1 удаа шавж устгал хийж 210000 төгрөгийн төсөв зарцуулсан.
- Фондын өрөөнд байнга нойтон цэвэрлэгээ хийж чийгшүүлэх зорилгоор савтай ус, мэрэгч амьтад хамгаалах хор тавьж, хлораминтай усаар тавиур болон номоо арчиж, ариутгаж байна.
- 2023 оны тогтмол хэвлэлийг 12 ширхэг нэгж болгон хавтас болгож, хуучин 2 ширхэг тогтмол хэвлэлийг сэлбэн зассан.
- Архивын фондын эргэлтийн судалгаа хийж, эргэлтийн судалгаагаар нийт номын 0.02 % -нь уншлагад гарсан байна. Иймд фондын эргэлтэд ороогүй номыг 7 хоног бүрийн 5 дахь өдөр номын мэдээ өгч сурталчлан ажиллаж байна.
- 2024 онд нийт 9 төрлийн 840700 төгрөгийн үнийн дүн бүхий тогтмол хэвлэл захиалж фондоо баяжуулсан. 2023 оны тогтмол хэвлэлээ нэгж болгон үдэж данс бүртгэл мэдээ тайланд тусгаж ажилласан.

## Гурав. Номын сангийн уншлага үйлчилгээний зохион байгуулалт

- 3.1 Номын сангийн үндсэн үйлчилгээ
- 3.2 Номын санд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр
- 3.3 Номын сангаас үзүүлж байгаа интернэт үйлчилгээ
- 3.4 Гэрээр ном олгох үйлчилгээ
- 3.5 Зөөврийн үйлчилгээ
- 3.6 Хүүхдийн танхимын үйлчилгээ
- 3.7 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд номын сангийн үйлчилгээ үзүүлсэн талаар
- 3.8 Соёл олон нийтийн ажил зохион байгуулсан талаар

### 3.1 Номын сангийн үндсэн үйлчилгээ

Манай номын сан уншлага үйлчилгээний 4 танхимаар үйлчилгээ, үйл ажиллагаа явуулж

2024 онд **15950** ирцэд **4800** шинэ уншигч бүртгэж, 1544 уншигчийн картыг сунгаж, 9606 байнгын уншигчдад **23600** ширхэг ном хэвлэл олгож үйлчиллээ.

Үйлчилгээг уншлага танхимууд, америкийн төвөөр гэр, зөөвөр гэсэн хэлбэрээр явуулж байна.
Үүнээс:

**Ном олголт**: Нийт **23600 ү**үнээс ном олгосноос уншлагын танхимаар 9469, гэрээр 12149, зөөврөөр 1982 ширхэг ном хэвлэл олгож үйлчилсэн байна.

Ном хангамж:  НФ-71906 / У-4800 =14,9
Ном уншилт: НО-23600 / У-4800 = 4,9
Фондын эргэлт: НО-23600 / НФ-71906 = 0,32

**Нийт олгосон номыг шинжлэх ухааны ангиллаар нь авч үзвэл:**

- Байгалийн шинжлэх ухааны 1170 ширхэг ном хэвлэл
- Техникийн шинжлэх ухааны 530 ширхэг ном хэвлэл
- Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны 279 ширхэг ном хэвлэл
- Анагаахын шинжлэх ухааны 181 ширхэг ном хэвлэл
- Социологи, статистикийн шинжлэх ухааны 1355 ширхэг ном хэвлэл
- Түүхийн шинжлэх ухааны 1355 ширхэг ном хэвлэл
- Эдийн засгийн шинжлэх ухааны 321 ширхэг ном хэвлэл
- Улс төрийн шинжлэх ухааны 396 ширхэг ном хэвлэл
- Төр эрх, хуулийн шинжлэх ухааны 396 ширхэг ном хэвлэл
- Цэргийн шинжлэх ухааны 46 ширхэг ном хэвлэл
- Соёл боловсролын шинжлэх ухааны 876 ширхэг ном хэвлэл
- Хэл шинжлэлийн ухааны 1131 ширхэг ном хэвлэл
- Аман зохиол, утга зохиолын 2529 ширхэг ном хэвлэл
- Уран зохиолын 13094 ширхэг ном хэвлэл
- Урлагийн 166 ширхэг ном хэвлэл
- Шашны 133 ширхэг ном хэвлэл
- Гүн ухааны 904 ширхэг ном хэвлэл
- Сэтгэл судлалын 998 ширхэг ном хэвлэл
- Лавлах мэдээллийн 278 ширхэг ном хэвлэл олгож үйлчилгээ үзүүлсэн.

**Хэлний байдлаар ангилахад:**

- Монгол 22806
- Орос 63
- Англи 357
- Бусад 374

**3.2 Номын санд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр:**

Манай номын сангиийн Америкийн төв нь олон нийт рүү хандсан олон төрлийн хөтөлбөр, сургалтуудыг явуулдаг бөгөөд англи хэл дээрх ном бүхий уншлагын танхим, чөлөөтэй ашиглах компьютерээр уншигч хэрэглэгч, олон нийтэд үйлчилж байна.
Ахлах ангийнхан болон насанд хүрэгчдэд зориулан ахисан шатны англи хэлний хичээлийг 2, 4 дэх өдрүүдэд 17:00 цагт, үгсийн сан, сонсголын хичээлийг 1, 3, 5 дах өдрүүдэд 16:00 цагт зохион байгуулж байна.
**Кино үдэшлэг:** 7 хоногийн баасан гарагийн орой бүр 17 цагаас бид уншлагын танхимдаа кино үдэшлэгийг зохиодог. Үйлчлүүлэгчид Холливудын шилдэг кинонуудаас авахуулаад Америкийн ард түмний амьдрал зан заншлыг харуулсан төрөл бүрийн бүтээлч, баримтат кинонуудыг үзэх боломжтой.
**Төвийн бусад сургалт, хичээлүүд:**

- Бага насныханд зориулсан хүүхдийн тоглоом.
- Хөтөлбөр, хэлэлцүүлэг болон бусад мэдээлэл.

2. ОЛОН НИЙТЭД ЗОРИУЛСАН ХӨТӨЛБӨРҮҮД

**1. SIP хөтөлбөр амжилттай хэрэгжлээ**

Номын сангийн дэргэдэх Америкийн төв нь 2023 оны 12 сарын 14-өөс 2024 оны 6 сарын 14 хүртэл сурагч дадлагажигч хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүллээ. Тухайн хөтөлбөрт нийт 20 хүүхэд өргөдөл илгээснээс 7 хүүхдийг сонгон шалгаруулж авсан. Сурагч дадлагажигч хөтөлбөрт шалгарсан 7 хүүхэд 3 багт хуваагдаж, 6 сарын турш дадлагажигчаар ажиллан ажлын байран дээр хөгжих, шинэ чадвар эзэмших, найз нөхдийн хүрээллээ тэлэх боломжтой болсон.
Сурагчид дараах 3 багт хуваагдсан. Үүнд:

Movie night
Speaking
Media team гэсэн багуудад хуваагдаж ажиллаж байна.

Дадлагажигч хөтөлбөрийн сурагчид өөрсдийн олж авсан мэдлэг, туршлага дээрээ үндэслэн UTP буюу гадаадын их сургуулиудад бэлтгэх хөтөлбөр нэртэй төсөл бичиж, амжилттай батлуулсан. Төслөө амжилттай батлуулсан сурагчид өөрсдийн бичсэн төслийн дагуу төслөө 2024 оны 5-р сарын 20-27-ний хооронд амжилттай хэрэгжүүлж дуусгалаа. Хөтөлбөрт нийт 43 өргөдөл хүлээн авснаас 12 хүүхдийг сонгон авсан. Сонгогдсон хүүхдүүд гадаадад суралцаж буй 5 зочин илтгэгчийн илтгэлийг сонсож, 6 бие даасан үйл ажиллагаа хийж, хөтөлбөрөө амжилттай төгслөө.

2.Энхтайваны корпусын сайн дурын ажилтан Даниял Америкийн төвд ажиллалаа. Энхтайваны корпусын сайн дурын ажилтан Даниял Америкийн төвд 2024 оны 1-р сарын 10-18-ны өдрүүдэд Америкийн төвд ажиллалаа. Даниял Америкийн төвд ажиллахдаа сурагч дадлагажигч хөтөлбөрийн сурагчдад 3 өдрийн сургалт зохион байгуулсан. Сургалтаар дадлагажигч нарт:

-  Хөтөлбөрөө хэрхэн төлөвлөх,
-  Хөтөлбөр төлөвлөхдөө анхаарах асуудлууд
-  Хөтөлбөрийн оролцогчоо тодорхойлох
-  Багаар ажиллах арга барил
-  Багаар ажиллахад хувь хүний зан төлөв хэрхэн нөлөөлдөг тухай
-  IELTS шалгалт өгөх болон заахад анхаарах зүйлс
-  Өөрийн амжилтын түүхээ бичиж эхлэх гэх мэт маш олон сэдвийн хүрээнд мэдээлэл өгсөн.

• 8-р сарын 1-17 Америкийн төвд гадаад багштай англи хэлний вакум сургалт явагдсан.Тус сургалтыг сайн дурын байгуллагын 2 багш ирж хичээл заасан.Нийт 15 сурагчид хамрагдсан.

- АНУ-ын элчин сайдын айлчлал: Энэ үйл ажиллагаа 2024 оны 9-р сарын 24-26-нд Америкийн төвд болсон. Энэхүү 3 хоногийн арга хэмжээнд нийт 450 хүн хамрагдсан.

- 9-р сарын 26-нд Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яамны Олон нийттэй харилцах албаны байгууллага Дезмэдээллийн сургалтад оролцсон орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчтэй уулзжээ. Мөн ТББ-ын төлөөлөгчтэй уулзаж, Элчин сайдын яамнаас хэрэгжүүлж буй Грант төслийн талаар мэдээлэл өгсөн юм. Нийт 20 хүн оролцсон.

- After school мөн ABC English хөтөлбөр нь бага ангийн сурагчдад англи хэлний анхан шатны хичээл, хүүхдэд тохирсон дуулах болон дасгал хийх боломжийг олгодог хөтөлбөр юм.Нийт 88 сурагч оролцсоноос давтагдсан тоо 705.

- Дунд ангийн англи хэлний хичээлийг 10-р сард төлөвлөн эхлүүсэн.Дунд ангийн сурагчдийн англи хэлний хичээл долоо хоногийн мягмар, пүрэв гарагт явагддаг. Хөтөлбөрт дүрмийн болон дүрмийн бус хичээлүүдээс гадна үгийн сангийн хичээлүүд багтдаг. Нийт 28 сурагч хамрагдсанаас давтагдсан тоо 180.

- АНУ-ын сонгуулийн өдөр

Арваннэгдүгээр сарын 6 бол АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулийн өдөр. Манай 5 төв уг үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй зохион байгуулсан.Нийт 15 хүн оролцсон.

- GEW- Эмэгтэй энтрепренерүүдийн сургалт

АНУ-ын элчин сайдын яам, Худалдааны хөгжлийн банк хамтран зохион байгуулсан "Эмэгтэй энтрепренерүүдийг дэмжих" өдрийг Төв номын сангийн Америкийн төвд зохион байгууллаа. Нийт оролцогчдын тоо 18.

- Америкийн уугуул иргэдийн өвийн сарыг тохиолдуулан 1-р сургуулийн 9-р ангийн 17 сурагчид АНУ-ын элчин сайдын яамнаас зохион байгуулсан цахим хөтөлбөрт оролцлоо.

- Илтгэлийн уралдаан

Олон Улсын Боловсролын Долоо хоногийн хүрээнд 1-р сургуулийн англи хэлний багш нартай хамтран дунд болон ахлах ангийн сурагчдын дунд англи хэлний уралдааныг амжилттай зохион байгуулж өндөрлөлөө.Нийт 38 сурагч оролцож ангилал тус бүрээс шагналт байрыг тодруулсан. Америкийн уугуул иргэдийн өвийн сарыг тохиолдуулан 1-р сургуулийн 9-р ангийн 17 сурагчид АНУ-ын элчин сайдын яамнаас зохион байгуулсан цахим хөтөлбөрт оролцлоо.

### 3.3 Номын сангаас үзүүлж байгаа интернэт үйлчилгээ

Номын сангийн дэргэд ажиллаж байгаа Америкийн төв нь олон нийтэд үнэгүй өндөр хурдны интернэт үйлчилгээ, хэлний танхимаар үйлчилдэг.
Энэ үйлчилгээг өдөрт 17 уншигч хэрэглэгч ашигладаг. Эхний хагас жилийн байдлаар 2265 хэрэглэгч уншигч ашигласан байна.

.Өөрийн номын сангийн вэб хуудсыг тогтмол шинэчлэх http://uvslibrary.weebly.com хаягыг 10 удаа шинэчилсэн байна.

Үүнд:

- Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу тусгай цэс нэмж хийсэн байна.

Социал медиа http://facebook.com/uvslib цахим хуудсыг http://uvslibrary.weebly.com цахим хаягтай холбон Номын санд зохиогдсон СОТ-ний ажлын тухай, мөн шинэ номын мэдээлийг тухай бүрд сурталчилсан..

АСМТөвд шинээр ирсэн 3 компьютерийг дахин шинээр үйлдлийн систем суулгаж, үйлчлүүлэгчдэд хялбар болгох үүднээс Deef freeze програм суулгалаа.

### 3.4 Зөөвөр, гэрээр ном олгох үйлчилгээ

2024 онд 32 байгууллагад, арга хэмжээнд давхардсан тоогоор 10 гаруй төрлийн шинжлэх ухааны, давхардсан тоогоор 1982 ширхэг номыг хүргэж, номын сангийн уншигчаар бүртгэж ном олгож үйлчилсэн.

Үүнд:

- “Хилийн цэргийн 0245-р ангид”- Хүүхдийн уран зохиолын 55 ширхэг ном
- Бөхийн өргөөнд “Туйл хайлах ёслол” – Аман зохиол 82 ширхэг ном
- Улаангом сумын “8-р цэцэрлэг”- Хүүхдийн уран зохиолын 56 ширхэг ном
- Улаангом сумын “13-р цэцэрлэг”- Хүүхдийн уран зохиол, Боловсролын шинжлэх ухааны -85 ширхэг ном

- ❖ Улаангом сумын Ерөнхий Боловсролын V-р сургуулийн- хэл шинжлэл, монголын уран зохиолын 50 ширхэг ном
- ❖ Улаангом сумын Ерөнхий Боловсролын IV-р сургуулийн- Хэл шинжлэл, монголын уран зохиолын 50 ширхэг ном
- ❖ "ХЦ-ийн 0245-р анги дээр Монголын уран зохиол, Хувь хүний хөгжлийн, Амьдрах ухааны 155 ширхэг ном
- ❖ Улаангом политехник коллеж дээр 89 ширхэг номоор үзэсгэлэн гаргаж 45 хүнд үйлчилсэн
- ❖ Номин худалдааны төвд уран зохиолын 87 ширхэг, Бусад шинжлэх ухааны 13ширхэг нийт 100 ширхэг номоор үйлчилгээ үзүүлсэн.
- ❖ "Ойрадын баатарлаг туульс хайлах ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаа"-нд Тууль, аман зохиолын 82 ширхэг номоор үзэсгэлэн гаргаж, уншигчийн карт нээж ном олгож ажиллалаа.
- ❖ Увс аймгийн Цагдаагийн сэтгэл зүйч Б.Энхзаяа 49 ширхэг ном зөөврөөр өгч үйлчиллээ.
- ❖ 2-р сургуулийн байрны багш Д.Сэргэлэнтэй хамтран дотуур байрны сурагчдын чөлөөт цагийн зөв боловсон өнгөрүүлж номтой нөхөрлүүлэх,ном уншихын ач тусыг таниулах зорилгоор "Номтой богц" аяныг зохион явуулж, 120 хүүхдэд,уран зохиолын болон хувь хүний хөгжлийн 136 номоор зөөврийн үйлчилгээ үйлчиллээ гэх мэт

Нийт зөөврийн үйлчилгээнд 1982 ширхэг номоор үйлчилгээ үзүүлсэн байна.

## Дөрөв. Лавлагаа, номзүйн үйл ажиллагаа

1. 2022 онд УИХ-аас батлан гаргасан шинэ хуульд карт бичиж, каталогийн шүүгээнд ялгагч хийж байрлуулж, стандартын дагуу хуулийн картын сангаа баяжуулсан.
2. 2023 оны сүүлийн улиралд байгууллагын хэрэгцээнд төсвөөр авсан болон хандиваар ирсэн 270 гаруй номоор шинэ номын номзүйн мэдээ гаргаж зааланд ашиглах, байгууллагын веб хаягт тавьж нийтийн хүртээл болгон ажиллаж байна.
3. Zotero программд 2023 оны Увсын өнгө сонины 18, Өглөөний сонины 239 мэдээлэлийг орууллаж Үндэсний тогтмол хэвлэлийн нэгдсэн цахим сан руу явууллаа.Мөн 2024 оны эхний хагас жилийн Өглөөний сонины 110 мэдээлэл оруулсан ба сүүлийн хагас жилийн мэдээллээ шивж байна.

## Тав. Католог зохион байгуулалт

Манай цахим каталогийн Uvs.lib4u.net хаягаар уншигч, хэрэглэгчид хайлт хандалт хийдэг.

Манай электрон каталогт 23,051 төрлийн 70,683 ширхэг ном, 184 төрлийн тогтмол хэвлэлийн 748 дугаар, 1 нийтлэл бүртгэгдсэн байна.

Мөн төрөл ангийн цаасан катологи хэвлэн каталогийн шүүгээнд стандартын дагуу байрлуулж хаягжуулсан.

**Зургаа. Номын сангийн орон нутаг судлах үйл ажиллагаа**

1. Орон нутаг судлалын сан хөмрөгийг баяжуулах, ашиглуулах зорилготой орон нутгийн зохиолчдын ном хэвлэлийг худалдан авах, орон нутгийн зохиолчдын номын нээлт, зохиолчдын уулзалт үдэшлэгийг байнга зохион байгуулж байна.
2. Орон нутгийн картын санг цаг хугацаанд нь орон нутгийн холбогдолтой болон орон нутгийн зохиолчдын ном хэвлэлээр баяжуулан ажиллаж байна.

- 2024 оны 5-р сарын 16-18-ны өдрүүдэд Ховд хотноо зохион байгуулагдсан "Баруун бүсийн соёл- утга зохиолын 3-р чуулган" болсон. Тус чуулганд Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хот, Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс аймгаас МЗЭ-ийн гишүүн яруу найрагчид, эрдэмтэн судлаачид, Соёл урлагийн газар, Нийтийн номын сангийн төлөөллүүд, МУИС-ийн Баруун бүсийн сургуулийн багш, оюутнууд, ЕБС-ийн багш, сурагчид нийт 300 гаруй оролцогч хамрагдлаа. Тус арга хэмжээнд Номын санч Д.Уранчимэг байгууллагаа төлөөлөн оролцсон.
- 2024 оны 5-р сарын 22-ны өдөр Монгол улсын Соёлын тэргүүний ажилтан Увс аймгийн Завхан сумын Соёлын төвийн эрхлэгч Х.Цэнджавын “Наран зүг нутаг минь” яруу найргийн номын нээлтийг зохион байгууллаа.
- Үндэсний бичиг соёл, Номын баяр-2024 арга хэмжээний хүрээнд “Зохиолч уншигчдын уулзалт” зохион байгууллаа. Энэхүү уулзалт үдэшлэгт МЗЭ-ийн Увс салбар "Огторгуйн далай" уран зохиолын нэгдлийн гишүүн яруу найрагчид оролцлоо.
- . МЗЭ-ийн гишүүн ,яруу найрагч Загдын Дамиран агсаны "Тэсийн унаганы янцгаа" шинэ номын нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа.
- Тод бичгээр бичигдсэн "Цэвэрүүний хангайн шил" шинэ номын нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа. Бөхнүүд овогт Нямын Шавганц нь 1940-өөд оны үеэс тод үсгийн шашны номыг сурч, томоохон шашины судар номыг уншиж олон түмэндээ буян хийж явсан нэгэн байжээ. Тэрээр өөрийн хүү Ш.Аюушдаа ном судраа өвлүүлэн үлдээж одоог хүртэл Увс аймгийн зон олондоо эцгээс үлдээсэн судар номоо уншиж буян хураасаар байгаа тод үсгийн шашны ном судартай цорын ганц хүмүүн билээ.
- Чорс тайж овогт Лодовын Дүгэрсүрэнгийн "Салхин хээтэй ай" шинэ номын нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа
- МУГБ, Хурандаа Манкадайн Мөнхбатын ХАНХӨХИЙН "ГАВЪЯАТ" ХУРАНДАА дурсамж дурдатгал номын танилцуулга /видео/хийлээ.
- “ИЛҮҮ ИХ УНШЪЯ” уриатай 36 дахь Номын баярын арга хэмжээний хүрээнд МУСГЗ,ахмад зохиолч яруу найрагч Б. Норов,Д.Мундааж,Б.Өлзий нарын бичлэг Увс аймгийн номын сангийн page хуудсан дээр байрлуулж 491 хүнд хүрсэн байна.
- Зохиолч-Уншигчдын уулзалт” зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Аймгийн Нийтийн номын сангийн дарга Б.Батхүү нээж үг хэлж, зохиолч, яруу найрагчдад Тод үсэг-375 ном бэлэглэж, нийт оролцсон уншигч сурагчдад сурлагын их амжилт хүслээ. МЗЭ-ийн Увс салбар "Огторгуйн далай" УЗН-ийн

тэргүүн Г.Оюун-Эрдэнэ, МУСГЗ, зохиолч яруу найрагч Б. Норов, МУСТ-зохиолч яруу найрагч Г.Пүрэвдорж, МУСТ-зохиолч яруу найрагч Б.Жаргалсайхан, Ардын авъяастан Л.Дүгэрсүрэн нар халуун яриа өрнүүлэхийн зэрэгцээ уран бүтээлээсээ уншиж сонирхууллаа. Мөн Увс аймгийн зохиолчдын номоор үзэсгэлэн гаргаж, /127 ширхэг ном/

МЗЭ-ийн гишүүн, яруу найрагч Г.Оюун-Эрдэнэ "Тонгоруу толины тусгал" хэмээх шинэ номоо манай номын санд ном бэлэглэлээ.

**Долоо. Номын сангийн мэдээлэл, технологийн үйл ажиллагаа.**

✓ **Увс аймгийн төв номын сан"- page-д нийтэлсэн мэдээлэл**

| № | Мэдээллийн нэр | Он.сар.өдөр | Хүртээмж | Сэтгэгдэл |
|---|---|---|---|---|
| 1 | 2024 оны 1-р дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхлэх хууль | 2024.01.02 | 546 | 6 |
| 2 | Цас цэвэрлэгээ хийлээ. / дотоод мэдээлэл/ | 01.10 | 211 | 1855 |
| 3 | Тууль хайлах ёслол | 01.31 | 1262 | 1205 |
| 4 | Э.Түдэв "Чамдаа би эрхлэх гэж төрсөн юм" шүлэг | 02.28 | 87 | 73 |
| 5 | Заавал унших 10 эсээ | 02.29 | 646 | 634 |
| 6 | "Сайхан Монгол ээж" ҮА-ны мэдээлэл | 03.5 | 2049 | 1961 |
| 7 | Бүтээлч ном уншдаг охидын зөвлөмж | 03.21 | 155 | 152 |
| 8 | Ном унших соёл ба номыг үр дүнтэй унших зөвлөгөө | 03.21 | 843 | 843 |
| 9 | Зөөврийн номын үйлчилгээ /13-р цэцэрлэг/ | 03.26 | 594 | 594 |
| 10 | Номын булан /13-р цэцэрлэг/ | 03.26 | 992 | 992 |
| 11 | Стресс тайлах аргууд /0-5 нас/ | 03.27 | 839 | 832 |
| 12 | Ном уншихын ач тус | 03.27 | 337 | 334 |
| | | | **8561** | **9481** |
| 13 | "СОЁЛЫН ӨВ" УЛСЫН УРАЛДААН БОЛНО | 04.11 | 239 | **17** |
| 14 | Шинэ ном ирлээ " Ц.Ядамсүрэн" | 04.16 | 329 | **8** |
| 15 | Шинэ ном ирлээ "Манлайлан дэвэгч..." | 04.16 | 569 | 13 |
| 16 | Шинэ ном ирлээ "Хууль ..." | 04.16 | 298 | 10 |
| 17 | "Соёлын өв" улсын уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг цувралаар хүргэж байна. №1 | 04.16 | | |
| 18 | "Соёлын өв" улсын уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг цувралаар хүргэж байна. №2 | 04.16 | 76 | 4 |
| 19 | "Соёлын өв" улсын уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг цувралаар хүргэж байна. №3 | 04.16 | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 20 | “Соёлын өв” улсын уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг цувралаар хүргэж байна. №4 | 04.16 | 62 | 3 |
| 21 | “Соёлын өв” улсын уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг цувралаар хүргэж байна. №5 | 04.16 | 52 | 0 |
| 22 | “Соёлын өв” улсын уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг цувралаар хүргэж байна. №6 | 04.16 | 94 | 7 |
| 23 | “Соёлын өв” улсын уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг цувралаар хүргэж байна. №7 | 04.16 | 57 | 1 |
| 24 | 35 дахь номын баяр /постер/ | 05.15 | 1845 | 99 |
| 25 | Мэргэжил сурталчилсан яриа пост | 05.15 | 238 | 11 |
| 26 | Баруун бүсийн соёл-утга зохиолын чуулган | 05.21 | 396 | 46 |
| 27 | “Наран зүг нутаг” номын нээлт | 05.24 | 334 | 54 |
| | | | **4589** | **273** |
| | **Хагас жилийн байдлаар** | | **13150** | **9754** |
| | **Жил эцсийн байдлаар** | Байгууллагын цахим хаягт **217 у**даа мэдээлэл оруулж **127236** хүнд хүргэж сурталчилсан байна | | |

**Найм. Аргазүйн үйл ажиллагаа**

1. Номын санчдыг чадавхжуулах, туршлага судлуулах хөгжүүлэх, үүднээс сумдын номын санчдын бүрэлдэхүүнтэй баг Наранбулаг,Өлгий, Өмнөговь, Ховд, Түргэн, Бөхмөрөн сумдын номын сангийн үйл ажиллагаатай танилцлаа.
2. Хөдөлмөрийн дээд сургуулийн номын сан дээр очиж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Данс бүртгэл хөтлөлт, фондын номын байрлалт эмх цэгц, номыг электрон каталогт оруулах зэрэг сэдвээр арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.
3. Хилийн цэргийн 0245-р ангийн номын санд мөн уншлагын танхмын номын санч номын үзэсгэлэн гаргаж үйлчилгээ үзүүлэх зэргээр хамтарч ажиллалаа.

4. ХЦ-ийн 0245-р анги дээр 2 удаагийн дамтамжтай Monbiblio программыг суулгаж өгөх, номын сангийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх.

**“Хамтдаа хөгжье” үйл ажиллагаа**

1. “Хамтдаа хөгжье” үйл ажиллагааг Цагаанхайрхан сумын Соёлын төвийн номын сан дээр зохион байгууллаа. Соёлын төвийн ажилчдыг оролцуулсан 4-5 номын санчдын бүрэлдэхүүнтэй баг ажиллаж, мэргэжлийн ажлыг гардан хийж стандартыг сайжруулах, шинэ 4 ширхэг зориулалтын тавиурыг угсарч 2500 ширхэг номын фондын номыг ангилж, стандартын дагуу байрлуулах, 1000 гаруй номыг бүрэн техник ажиллагаа хийж электрон каталогт оруулж бар коджууллаа. Мөн уншлагын танхимд ойрын фондыг шинээр зохион байгуулсан.

2. “Хамтдаа хөгжье” бүсчилсэн үйл ажиллагааг Хилийн цэргийн 0245-р ангийн номын сан дээр зохион байгуулах мэргэжлийн ажлыг гардан хийж стандартыг сайжруулах. номын санч, хилийн цэргийн ажилчдаас бүрдсэн 9 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллалаа.

- ❖ Энэхүү үйл ажиллагааны бүрэлдэхүүнд Төв номын сангийн аргазүйч миний бие ахалж Тариалан сумын Соёлын Төвийн номын санч Н. Нансалмаа, Түргэн сумын Соёлын төвийн номын санч Т. Амарзаяа, Сагил сумын Соёлын Төвийн номын санч Э. Энхцэцэг,Улаангом сумын номын санч Д. Алтанчимэг, Хилийн цэргийн номын санч Б. Болормаа болон Хилийн цэргийн Соён гэгээрүүлэх тасгийн 3 албан хаагчдаас бүрдсэн баг 3 хоног ажиллаж мэргэжлийн ажлыг гардан хийж стандартыг сайжруулах. Үндсэн фондын 1200 гаруй номыг ангилах, данслах, үнэлэх, электрон каталогт оруулж бар коджуулах, бар кодыг нааж шинжлэх ухааны салбараар нь төрөлжүүлж байрлуулах ажлыг хийж тухайн номын сангийн үйл ажиллагааг сайжруулах номын сангийн стандартад нийцүүлж жишиг номын сан болгох тал дээр анхаарч ажиллалаа.

  Хилийн цэргийн 0245-р ангийн захирагч нар энэхүү үйл ажиллагааг дэмжиж баг бүрэлдэхүүнээ сайтар зохион байгуулж ажиллалаа.

3. “Хамтдаа хөгжье” бүсчилсэн үйл ажиллагааг Бөхмөрөн сумын Соёлын төвийн номын сан дээр зохион байгуулах мэргэжлийн ажлыг гардан хийж стандартыг сайжруулах. номын санчдаас бүрдсэн 8 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллалаа.

- ❖ Энэхүү үйл ажиллагааны бүрэлдэхүүнд Төв номын сангийн аргазүйч миний бие ахалж Тариалан сумын Соёлын Төвийн номын санч Н. Нансалмаа, Түргэн сумын Соёлын Төвийн номын санч Т. Амарзаяа, Бөхмөрөн сумын Соёлын төвийн номын санч Т. Отгонбаяр Бөхмөрөн сумын сургуулийн номын санч С. Эрдэнэчимэг нар болон тус сумын Соёлын Төвийн ажилчдаас бүрдсэн баг 3 хоног ажиллаж мэргэжлийн ажлыг гардан хийж стандартыг сайжруулах. Үндсэн фондын 2000 гаруй номыг ангилах, данслах, үнэлэх, электрон каталогт оруулж баркоджуулах, бар кодыг нааж шинжлэх ухааны салбараар нь төрөлжүүлж байрлуулах ажлыг хийж тухайн номын сангийн үйл ажиллагааг сайжруулах номын сангийн стандарт нийцүүлэх, үйл ажиллагааг дэмжих ажиллагаа явуулсан.

Соёлын төвийн эрхлэгч Б. Баяржавлан энэхүү үйл ажиллагааг дэмжиж баг бүрэлдхүүнээ сайтар зохион байгуулж ажиллалаа.

3. "СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР”-ын нөлөөллийн ажлын хүрээнд 11-р сарын 11,16 нд зорилтод бүлгийн хүүхэд рүү чиглэж 2 өдрийн арга хэмжээ зохион байгуулж явууллаа.

1. 11-р сарын 11 нд аймгийн БТСГ-тай хамтран монгол уламжлалт тоглоом наадгай: морь уралдуулах, шагай няслах тэмцээн зохион байгуулж "Өргөмжлөл" олимпын хорооны энгэрийн тэмдэг, 100.0 төгрөгөөр шагнаж урамшуулав.

2. 11-р сарын 16 нд Аймгийн Нийтийн номын сан дээр сургалт зохион байгуулах, музей үзүүлэх, хичээлийн хэрэглэгдэхүүн, хувцас бэлэглэх зэрэг

арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.
3. Сургалтыг "Сэтгэл зүйн" ухааны докторант Н .Баатар "Өөртэй итгэх, сэтгэл мэдрэмжээ удирдахуй" сэдвээр сургалт орсонд талархал илэрхийлье.
Тус арга хэмжээг ивээн тэтгэсэн албан байгууллага, худалдаа эрхлэгч нарт талархсанаа илэрхийлье.
Үүнд:
- Өнхрүүш бэйкери
- Интер ном
- Титэм худалдааны төв
- Зогсоо хайрхан зоогийн газар
- Захын худалдаа эрхлэгч:
- Д. Нарантуяа
- Д. Оюунчимэг
- Х. Тамжав
- Ц. Отгонцэцэг /Ундрам дэлгүүр/
- Ц. Нарантуяа
- И. Ариунаа болон бусад оролцсон хүмүүст маш их баярлалаа.

Энэхүү үйл ажиллагааг зохион байгуулахад хамтран ажилласан:
Зая Бандида Намхайжамцын нэрэмжит аймгийн Нийтийн номын сан
ХГБХХГ-ын мэргэжилтэн Ц. Солонго
БТСГ-ын дарга Баяртуул, мэргэжилтэн Г.Чулуун
ХХҮГ-ын мэргэжилтэн Д. Оюунчимэг
Улаан загалмайн хороо
Аймгийн музейн хамт олонд талархал илэрхийлье.

**Ес. Зохиогдсон соёл олон нийтийн ажил :**

**2024 онд** Соёл танин мэдэхүйн чиглэлээр **89 ажил** зохион байгуулж **нийт 7121** иргэдийг хамруулсан.**Үүнд:**

**1.** УПК-ын оюутнуудын дунд номын хэлэлцүүлэг зохион явууллаа.Үүнд:
Л.Өлзийтөгс "Үзэхийн хязгаар" номоор Ц. Гэрэлзул
Л.Мөнгөнчимэг "Мөрөөдөгч" номоор Н.Сувд-Эрдэнэ яриа хийж, номыг хэрхэн шимтэн унших, дадлын талаар харилцан ярилцлаа.

2. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийн хамгаалах өдрийг угтан Нийтийн номын сангийн ажилчдын дунд "**Сайхан Монгол ээж**" эвент зохион байгууллаа.

Уг арга хэмжээнд:
- ажилчид ээжийн тухай афоризм бичиж ээжтэйгээ хамт авхуулсан зургаа өөрийн хаягт хаштаг / #сайханМонголээж/ ашиглан нийтлэх
- Зохион байгуулагчдын хүлээн авалт, мэндчилгээ
- Ээжтэйгээ хамт авхуулсан зургийн тухай дурсамж яриа
- Зохион байгуулагчдын гарын бэлэг

(Хамтран зохион байгуулагчид: Д.Уранчимэг, Л.Алтанцэцэг, Н.Нямаа)

3. Үндэсний бичиг соёл, Номын баяр-2024 арга хэмжээний хүрээнд "**Зохиолч-Уншигчдын уулзалт**" зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Аймгийн Нийтийн номын сангийн дарга Б.Батхүү нээж үг хэлж, зохиолч, яруу найрагчдад Тод үсэг-375 ном бэлэглэж, нийт оролцсон уншигч сурагчдад сурлагын их амжилт хүслээ. МЗЭ-

ийн Увс салбар "Огторгуйн далай" УЗН-ийн тэргүүн Г.Оюун-Эрдэнэ, МУСГЗ, зохиолч яруу найрагч Б. Норов, МУСТ-зохиолч яруу найрагч Г.Пүрэвдорж, МУСТ-зохиолч яруу найрагч Б.Жаргалсайхан, Ардын авъяастан Л.Дүгэрсүрэн нар халуун яриа өрнүүлэхийн зэрэгцээ уран бүтээлээсээ уншиж сонирхууллаа. Мөн Увс аймгийн зохиолчдын номоор үзэсгэлэн гаргаж, /127 ширхэг ном/

МЗЭ-ийн гишүүн, яруу найрагч Г.Оюун-Эрдэнэ "Тонгоруу толины тусгал" хэмээх шинэ номоо манай номын санд ном бэлэглэлээ.

4 Үндэсний бичиг соёл, Номын баяр- 2024", 09.13

36 дахь Номын баярын арга хэмжээний хүрээнд "ИЛҮҮ ИХ УНШЪЯ" уриатай " **Номтой үдэш"**-ийг зохион явууллаа. Уг арга хэмжээнд "Номын уншихын ач тус", Цахим орчны зохисгүй хэрэглээнээс хүүхдийг холдуулж номонд хэрхэн дурлуулах талаар харилцан ярилцлаа. ХДС-ийн 19 оюутан оролцлоо. Хамтран зохион байгуулсан ХДС-ийн багш Золзаяа

5. "ИЛҮҮ ИХ УНШЪЯ" уриатай 36 дахь Номын баярын арга хэмжээг угтаж танин мэдэхүйн "**АХА" тэмцээн** зохион явууллаа. Тэмцээнд 112 хүүхэд оролцсон. Үүнд:

1-р байр: А. Алтангэрэл 2-р сургуулийн 11-в анги

2-р байр: Ц.Түмэнбаяр 2-р сургуулийн 11-е анги

3-р байр: Г. Урангуа 2-р сургуулийн 11-б анги тус бүр эзэллээ.

Хамтран ажилласан ЕБ-ын 2-р сургуулийн байрны багш Д.Сэргэлэн.09.18

20. "ИЛҮҮ ИХ УНШЪЯ" уриатай 36 дахь Номын баярын арга хэмжээний хүрээнд МУСГЗ,

ахмад зохиолч яруу найрагч Б. Норов,Д.Мундааж,Б.Өлзий нарын бичлэг Увс аймгийн номын сангийн page хуудсан дээр байрлуулж 491 хүнд хүрсэн байна.09.17

21. Үндэсний бичиг соёл ,Номын өдрүүд-2024",36 дахь номын баярын арга хэмжээний хүрээнд Чорс тайж овогт Лодовын Дүгэрсүрэнгийн "Салхин хээтэй ай" шинэ номын нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа.

Тус арга хэмжээнд Номын сангийн дарга Б.Батхүү номын нээлт хийж үг хэллээ.

4-р сургуулийн 12-а ангийн сурагч Ж. Эрхэмбаяр морин хуураар Жалам хар аялгуу

тоглож, Цэрэвийн нэрэмжит Ойрад театрын дуучин СТА Ц.Цэгмэд ая дуугаа өргөж,

Увс аймгийн "Огторгуйн далай " утга зохиолын нэгдлийн хамт олон уран

бүтээлийнхээ дээжээс уншиж толилууллаа. Мөн Л.Дүгэрсүрэнгийн үр

хүүхдүүд,төрөл төрөгсөд,ах дүү нар нь болон оюутан сурагчид нийт 29 хүн оролцлоо.

22. Үндэсний бичиг соёл ,Номын өдрүүд-2024",36 дахь номын баярын арга хэмжээний хүрээнд хүүхэд залуусыг номтой нөхөрлүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, ном унших дадлыг төлөвшүүлэх зорилготой оюутан, сурагчдын дунд "Уншигчдын бага хурлыг зохион явууллаа. Уг арга хэмжээнд: 75 сурагч

23. "Цахим хэрэглээг цагийн хязгаартай ашиглах" сэдвээр яриа хийлээ.

24. "Тэргүүний уншигч-Д.Нацагдорж " тэмдэгтэн 4-р сургуулийн 12-б ангийн сурагч Ж.Эрхэмбаяр "Талархлын хүч","Аяга кофены бясалгалаар тэрбумтан болсон хүмүүс" 2 номоор яриа хийлээ.

25. ЕБ-ын 4-р сургуулийн 12-б ангийн сурагч А.Буянзаяа Хулан Н.“The girl in my mirror : Өөрийгөө олох аяллын тэмдэглэл" номоор яриа хийлээ.
26. 2-р сургуулийн 12-д ангийн сурагч Г.Мөнхжин “Миний ээж өрөөсөн нүдтэй” өгүүллэг уншиж сонирхуулллаа. Нийт 88 оюутан,сурагчид оролцлоо.Хамтран ажилласан фондын номын санч Д.Уранчимэг 09.23
27. "Үндэсний бичиг соёл,Номын өдрүүд-2024",36 номын баярын арга хэмжээний хүрээнд үндэснийхээ бичиг соёлыг залуу хойч үедээ суртачилан өвлүүлэх,шилдэг сайхан бичигтнийг тодруулж алдаршуулах бичгийн хэв зурлага,уран чадварын онцлогийг таниулах зорилгоор "Монгол бичгийн уран бичлэг"-ийн уралдааныг УПК-ын сурагчдын дунд зохион явууллаа. Үүнд 74 сурагчид оролцсон. Хамтран ажилласан УПК-ын багш Б.Батхишиг болон номын санч Я.Нансалмаа, Б.Бурмаа 09.23
1- р байр: БЗЧ-2-р анги Батзориг
2- р байр: ХГД-1-р анги Б.Ганбат
3- р байр: ХГД-1-р анги Б.Сувд-Эрдэнэ
Тусгай байр: ХГД 2-р анги Цэнгэл
Тусгай байр: БЗЧ 2-р анги Цэвээнгэрэл нар тус тус шалгарлаа.
Соёлын бүтээлч сар аяны хүрээнд:
- Тод бичгээр бичигдсэн "**Цэвэрүүний хангайн шил**" шинэ номын нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа. Бөхнүүд овогт Нямын Шавганц нь 1940-өөд оны үеэс тод үсгийн шашны номыг сурч, томоохон шашины судар номыг уншиж олон түмэндээ буян хийж явсан нэгэн байжээ. Тэрээр өөрийн хүү Ш.Аюушдаа ном судраа өвлүүлэн үлдээж одоог хүртэл Увс аймгийн зон олондоо эцгээс үлдээсэн судар номоо уншиж буян хураасаар байгаа тод үсгийн шашны ном судартай цорын ганц хүмүүн билээ. Уг номыг хайрт аав Бөхнүүд овогт Нямын Шавганцын гэгээн дурсгалд зориулж дөрвөд түмний их өв соёлын нэг хэсэг болох уртын дуу болон тод бичгийг нутагшуулж энэхүү номоо үндэсний босоо бичиг болон крилл бичгээр хослуулан хэвлүүлжээ. Дөрвөд ут дуу 360 эхтэй гэх буюу 360 төрлийн шашин газар нутаг, хүлэг морьд, аав ээж, амраг ханиа магтан дуулсан байдаг. Мөн тод бичгийн талаар Ш.Аюуш гуай телевизэд яриа өглөө.
- Бөхийн өргөөний нээлтийн арга хэмжээнд:

Шинэ номын, Ойрадын урт дууны номоор тус бүр үзэсгэлэн гаргалаа.
- Төр нийгмийн нэрт зүтгэлтэн, БНМАУ-ын баатар, Маршал Ю.Цэдэнбал

Баабар. “**Юмжаагийн Цэдэнбал**”номын танилцуулга
- Ном уншихын ач тус зөвлөмж
- "**Маршал Ю.Цэдэнбалыг хэн сайн мэдэх вэ**"АХА тэмцээнийг ЕБС-ийн 10-11 ангийн сурагчдын дунд зохион байгууллаа. /видео/
- Ойрадын уртын дууны номоор үзэсгэлэн /видео/
- П.Нотоо Баяд ардын уртын дууны түүвэр номын танилцуулга /видео/
- Ойрадын болон баяд ардын уртын дууны тухай /видео/
- Дөрвөд ут дуу Ш.Аюуш /видео/
- Увс аймгийн Нийтийн номын сан нь Увс аймгийн Хөдөлмөрийн дээд сургуулийн номын сан, Ойрадын уртын дууны холбоотой хамтран "**ОЙРАДЫН УТ ДУУТАЙ НЭГ ӨДӨР"** эвент зохион байгуулж нэг өдөр үндэсний их өв соёл болсон уртын дуугаа эгшиглүүлж өнгөрүүллээ. Нийт 36 хүн оролцлоо.

	Увс аймгийн Нийтийн номын сан нь, Увс аймгийн ЗДТГ, ХХҮГ, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллага, Улаангом сумын соёлын төвтэй хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд”-ийн өдөрлөг зохион байгууллаа.
Энэхүү арга хэмжээнд: АХА тэмцээнийг зохион явууллаа. Мөн Монголын уран зохиол, Амьдрах ухаан, Хүүхдийн уран зохиолын номоор үзэсгэлэн гаргаж, карт нээж, ном олгож үйлчиллээ.
28. "Ойрад Монгол судлалын хүрээлэн /Тод номын гэрэл төв/"-ээс эрхлэн хэвлүүлэн гаргасан цуврал болон Шилдэг шинэ номоор тус бүр үзэсгэлэн гаргаж ажиллалаа.
29. Уншлагын танхимд шинээр ирсэн номын мэдээг шинжлэх ухааны ангилалаар нь цувралаар танилцууллаа. /видео/
30. МУГБ, Хурандаа Манкадайн Мөнхбатын ХАНХӨХИЙН "ГАВЪЯАТ" ХУРАНДАА дурсамж дурдатгал номын танилцуулга /видео/
31. Ойрадын түүх өв соёл хэлэлцүүлэг хийлээ
32. 35 дахь удаагийн номын баяр, "Эх бичиг, соёл, номын өдрүүд-2024" арга хэмжээний хүрээнд харааны бэрхшээлтэй иргэдийн дунд "АХА" тэмцээнийг зохион байгууллаа.Энэхүү арга хэмжээнд нийт 10 хүн оролцсон бөгөөд үүнээс Б.Отгонжаргал нэгдүгээр байр эзэлж, шагнал, дурсгалын зүйл гардуулав. Л.Анхзаяа хоёрдугаар байр эзэлж, шагнал, дурсгалын зүйл гардууллаа.
33.Улаангом сумын Засаг даргын Тамгын газар "Ногоон хот - Бидний оролцоо" сэдэвт нийтийн явган аялал зохион байгууллаа. Энэхүү нийтийн алхалтын аянд нэгдэж, мод тарих, байгаль дэлхийгээ хүндэтгэх, уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулааралтай тэмцэхийг уриаллаа.Нийт 500 орчим сургуулийн сурагч, албан байгууллагын ажилчид оролцсон.
34. “Миний Хөөрхөн шүдний аялал” номоор бэлтгэл бүлгийн хүүхдүүдэд чанга уншлага явууллаа. /Арга хэмжээнд нийт 40-гаруй хүн хамрагдлаа./

/Хамтран ажилласан. Д.Уранчимэг, Б.Биньеэ, Н.Нямаа/

35.Улаангом сумын ЕБ-ын V-р сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд мэргэжил сурталчлах өдөрлөг буюу “Номын санч гэж хэн бэ?” яриа хийж, гарын авлага тарааж ажиллаа. /Арга хэмжээнд нийт 60-гаруй хүн хамрагдлаа./

/Хамтран ажилласан. Д.Уранчимэг, Л.Алтанцэцэг/

36.Улаангом сумын ЕБ-ын IV-р сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд мэргэжил сурталчлах өдөрлөг буюу “Номын санч гэж хэн бэ?” яриа хийж, гарын авлага тарааж ажиллаа. /Арга хэмжээнд нийт 30-гаруй хүн хамрагдлаа./

/Хамтран ажилласан. Д. Уранчимэг, Л.Алтанцэцэг, Н.Алтансүх/

37. Улаангом сумын ЕБ-ын I-р сургуулийн дунд ангийн сурагчдад “Ном унших соёл” сэдвээр яриа хийлээ. /Арга хэмжээнд нийт 60-гаруй хүн хамрагдлаа./

/Хамтран ажилласан. Д.Уранчимэг, Ч. Жаргал/

38. 2024 оны 5 сарын 16-18-ны өдрүүдэд Ховд хотноо зохион байгуулагдсан "**БАРУУН БҮСИЙН СОЁЛ-УТГА ЗОХИОЛЫН III ЧУУЛГАН**" –д оролцлоо. Тус чуулганд Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хот, Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс аймгаас МЗЭ-ийн гишүүн яруу найрагчид, эрдэмтэн судлаачид, Соёл урлагийн газар, Нийтийн номын сангийн төлөөллүүд, МУИС-ийн Баруун бүсийн сургуулийн багш, оюутнууд, ЕБС-ийн багш, сурагчид нийт 300 гаруй оролцогч хамрагдлаа.

8. 2024 оны 05 сарын 22-ны өдөр Монгол улсын Соёлын тэргүүний ажилтан Увс аймгийн Завхан сумын Соёлын төвийн эрхлэгч Х.Цэнджавын **“НАРАН ЗҮГ НУТАГ”** шүлгийн номын нээлтийг зохион байгуулахад оролцлоо. /20 хүн оролцсон/
9. 2024 оны 06 сарын 17-ны өдөр Хөхөөнхөн овогт Цэвээний Энхбаатар "Хөхөөнхөн овогтны угийн бичиг" номын нээлтийг зохион байгуулахад оролцлоо. /40 хүн оролцсон/
10. 2024 оны 9 сарын 28нд Тариалан суманд үйл ажиллагаа явуулж буй хөгжлийн бэрхшээлтэй охины өөрийн санаачлагаар байгуулсан “Найдвар” номын сан дээр очиж ажиллаж мэргэжил арга зүйн зөвлөгөө тусламж үзүүллээ. /7 хүн оролцсон/
11. “Нүүдэлчин” олон улсын соёлын фестивалд “Уламжлалт тоглоом найдгай”-төрлөөр үзэсгэлэн гаргаж оролцсон. /мянга гаруй хүн/
12. Ахлах ангийн сурагчдад мэргэжлээ сонгоход нь номын санч мэргэжлийн онцлогийг сурталчлах зорилгоор ЕБ-ийн VI-р сургуулийн 10-р ангийн сурагчдад мэдээлэл хийж, тараах материал өгч ажиллаа. / 20 сурагч/
13. Ном унших ашиг тусыг сурталчлах зорилгоор Хүүхдийн заалны номын санч Ч.Жаргал номын санчтай хамтран Эрдмийн эхлэх сургуулийн 2-р ангийн сурагчдад “Үлгэрийн баатар номонд” сэдвээр яриа хийлээ. / 20 гаруй сурагч хамрагдсан./
14. ЕБ-ын V-р сургуулийн номын санч, дунд ангийн 3 сурагчтай хамтран “Эмч зөгий” ном эмчлэх уриалга аяныг Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг ЕБС-ийн сурагчдад хүргэх зорилгоор “Увс нам бус” ТВ-гээр бичлэг хийлгэж олон нийтийн сүлжээнд байрлууллаа.
15. Номын санч мэргэжлийн онцлогийг сурталчлах зорилгоор Улаангом сумын соёлын төвийн номын санч Д. Алтанчимэгийн ажлын онцлогийг сурталчилсан мэдээ бэлтгэж олон нийтийн сүлжээнд байрлууллаа.
16. ЕБ-ийн V-р сургуулийн дотуур байрны хүүхдүүдэд “Ном унших ашиг тус, Цахим хэрэглээг цагийн хязгаартай ашиглая” сэдвээр Улаангом сумын соёлын төвийн номын санч Д. Алтанчимэгтэй хамтран яриа хийлээ. /45 сурагч хамрагдсан./
17. Аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг ЕБС- болон Улаангом политехникийн коллежийн сурагчдын дунд “Уншигч сурагчдын бага хурал” арга хэмжээг номын санч Б.Биньетэй хамтран зохион байгууллаа. / 75 сурагч хамрагдсан./
18. Хүүхдийн уншалагын зааланд “Ном унших соёл” болон “Хүүхдийн уншлага удирдах нь “ сэдвээр эцэг эх, сурагчдад яриа хийсэн. / 29 эцэг эх, сурагч хамрагдсан./
19. Соёлын бүтээлч сар “Ахмадуудтай нэг өдөр” эвент номын санч Л.Алтанцэцэгтэй хамтран зохион байгуулсан. / 60 ахмад хамрагдсан./
20. Соёлын бүтээлч сар “Ойрадын ут дуутай өдөр” эвент номын санч Б.Биньетэй хамтран зохион байгуулсан. / 36 хүн хамрагдсан./
21. Улаангом сумын V-р цэцэрлэгийн “Номын сангийн нээлт”-д оролцсон. /50 гаруй хүн хамрагдсан.

39. Соёлын бүтээлч сар 2024 сарын аяны хүрээнд Ойрад Монгол судлалын хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлсэн 120 гаруй номоор цахим контент бүтээж сарын турш 4 хуваан сурталчилж давхардсан тоогоор 4000 гаруй хүний хандалт авсан.
40. 35 дахь Номын баярын арга хэмжээ болон "Уншигч Увсчууд" аяны хүрээнд Төрийн албан хаагчдын монгол бичиг сурах идэвхийг өрнүүлэх, уншлагын хурд

болон бичгийн чадварыг дээшлүүлэх зорилгоор “**Монгол бичгийн уралдаан**”-ыг зохион байгууллаа.
Тус уралдаанд:
1-р байр: ЕБ-ын 6-р сургуулийн баг
2-р байр : Улаангом сумын ЗДТГ-ын баг
3-р байр: НДХ-ийн баг
Тусгай байр: Харааны бэрхшээлтэй иргэдийн холбооны баг тус тус эзэлж Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа. Нийтдээ 22 төрийн албан хаагч оролцлоо.
41. Дэлхийн номын өдөр болон Улсын тэргүүний 5-р цэцэрлэгийн түүхт 50 жилийн ойг тус тус угтан цэцэрлэгүүдийн дунд зохион байгуулагдсан "**Үлгэрийн баатрууд амилсан нь** " уралдаан амжилттай болж шагналаа гардууллаа.
Тус уралдаанд нийт 25 цэцэрлэгийн бүтээл ирснээс 2 үе шаттайгаар шалгаруулж 2-р шатанд үлдсэн багуудаас :
1-р байр: 9-р цэцэрлэгийн "Болдоггүй бор өвгөн" үлгэрийн жүжигчилсэн тоглолт
2-р байр: 1-р цэцэрлэгийн "Халиартай бин " үлгэрийн жүжигчилсэн тоглолт
2-р байр: 6-р цэцэрлэгийн"Бэтгэлжин бор шувуу" үлгэрийн жүжигчилсэн тоглолт
3-р байр: Давст сумын Гэрэлт ирээдүй цэцэрлэгийн "Гурван тоорой" үлгэрийн жүжигчилсэн тоглолт
3-р байр: Тариалан сумын цэцэрлэгийн "Эрх бяцхан хулгана" үлгэрийн жүжигчилсэн тоглолт
42. Бүх нийтийн соёлын боловсролыг төлөвшүүлэх, нөлөөллийн ажлыг зохион байгуулах зорилгоор Увс аймгийн Цагдаагийн газрын бие бүрэлдэхүүний өглөөний ярианы цагийг Нийтийн номын сан дээр зохион байгуулж тэдэнд байгууллагынхаа үйл ажиллагааг танилцуулах , сан хөмрөг, АСМТөв, хүүхдийн болон уншлагын танхимуудын үйл ажиллагааг суртачлах, номын сангийн уншигчаар бүртгүүлж ном авч унших талаар, хүүхэд багачуудаа номонд яаж дурлуулах ,өөрснөө номын сангаар хэрхэн үйлчлүүлэх, хүүхдүүд, гэр бүл, алба хагчид англи хэл сурах ямар боломж байгааг тайлбарлалаа.
Мөн бие бүрэлдэхүүнд зориулж Монголын уран зохиол,Амьдрах ухаан,Төр эрх, хууль сэдвээр нийтдээ 80 гаруй номоор үзэсгэлэн гаргаж, 22 алба хаагчид номын сангийн уншигчийн карт нээж үйлчиллээ.Оролцсон хүний тоо-60
43. . Онцлох хүн Заябандида Намхайжамцтай холбоотой номын үзэсгэлэнгүүдийг цахим хэлбэрээр суртачиллаа.
44. ДОЛОО ХОНОГИЙН ОНЦЛОХ ТҮҮХЭН ХҮН# Зая бандид Намхайжамц” цахим танилцуулага хийж иргэдэд срталчиллаа.
45. МОНГОЛ ТОД БИЧИГ ҮСГИЙН ТУХАЙ цахим мэдээллийг сурталчиллаа.
46. Төр нийгмийн нэрт зүтгэлтэн, БНМАУ-ын баатар, Хөдөлмөрийн баатар, маршал Ю.Цэдэнбалын намтар амьдралын товчоог цахимаар суртачиллаа.
47.. Долоо хоногийн онцлох түүхэн хүн Төр нийгмийн нэрт зүтгэлтэн, БНМАУ-ын баатар, Хөдөлмөрийн баатар,Маршал Ю.Цэдэнбалтай холбоотой номын үзэсгэлэнгүүдийг дэлгэж уншигчиддаа цахимаар сурталчиллаа.
48. О. ДАШБАЛБАРЫН "МАРШАЛ ЦЭДЭНБАЛ" НАЙРАГЛАЛЫГ МУСГЗ Ш. ЁОЛКЫН уншсанаар цахимд тавьж сурталчиллаа.
49. Төр нийгмийн нэрт зүтгэлтэн БНМАУ-ын баатар, Хөдөлмөрийн баатар,маршал

Ю.Цэдэнбал нь ном хэвлэлээс гадна кино,болон дууны урлагт цахим сурталчилгааг хийв.
50. ГЭРЭЛ ЗУРАГ ТҮҮХ ӨГҮҮЛНЭ. Төр нийгмийн нэрт зүтгэлтэн БНМАУ-ын баатар, Хөдөлмөрийн баатар,маршал Ю.Цэдэнбалын зурагт танилцуулга хийлээ.
51. УРАН УНШЛАГА
Улсын тэргүүний 1-р сургуулийн 12-р ангийн сурагчид МУСГЗ Б.Норовын 2006 онд зохиосон "Миний Маршал" шүлгийг бүх нийтээрээ уншлаа.Оролцёон хүний тоо-20
52. #УРТЫН ДУУГ ОНЦЛОХ 7 ХОНОГ#
ДӨРВӨД АРДЫН УРТЫН ДУУ" ХАРГАА САЙХАН ХЭЭР" дууг сурталчиллаа.
53. #УРТЫН ДУУГ ОНЦЛОХ 7 ХОНОГ# ДӨРВӨД АРДЫН УРТЫН ДУУ
54. "БУГА БИЕТЭЙ ХАЛТАР"дууг сурталчиллаа.
55. ОЙРАД МОНГОЛЧУУДЫН ТҮҮХ СОЁЛЫГ СУРТАЧЛАН ТАНИУЛАХ ЗОРИЛГООР "ДӨРВӨН ОЙРАДЫН ХОЛБОО"-НЫ ТАЛААР ТОВЧ ТҮҮХИЙГ ӨГҮҮЛСЭН ПОСТЕР ОРУУЛЛАА.
56. ОЙРАД МОНГОЛЧУУДЫН ТҮҮХ "ПОСТЕР ОРУЛЛАА.
57. Дөрвөд аялгын талаар постер хийж сурталчиллаа.
58. Үлгэрээр дамжуулан хүүхдийг хөгжүүлэх, өрх гэр бүлүүдийн хамтын ном уншлага бүтээлч байдлыг дэмжих зорилготой “Номтой нэг өдөр” арга хэмжээг ЕБС-ийн 3-р сургуулийн О.Янжиндулам багштай 4б ангийн эцэг эхчүүд, сурагчдын дунд зохион байгууллаа.
59. Улсын тэргүүний Солонго 4-р цэцэрлэгийн Бэлтгэл 1,2-р бүлгийн хүүхдүүдэд “Улаан малгайт Пэти”, “Гал сөнөөгч”, “Дуулгавартай байцгаая”, “Зааны тугал”,” Гайхамшигт цасан хүн” номуудаар “Чанга уншлага” хийлээ.
60. Өглөөний гайхамшиг- Увс” группийн админ Б.Булганцэцэгээр Цогцолбор 1-р сургуулийн Д.Хишигдэлгэр багштай 8д ангийн сурагчдад “Өглөөний гайхамшиг- түүнийг хэрхэн хэрэгжүүлэх” тухай “ Бид чадна” нэртэй яриа хийлгэлээ.
61. хүрээнд ЕБС-ийн 7,8-р ангийн сурагчдын дунд монгол бичгийн хичээлийн мэдлэг бататгах зорилготойгоор “Алтан хонх” тэмцээнийг зохион явууллаа. Тэмцээнд 30д хүүхэд оролцсоноос ЕБС-ийн 5-р сургуулийн 7б ангийн сурагч Б.Анхзаяа тэргүүлж ЕБС-ийн 3-р сургуулийн 7б ангийн сурагч Б.Ариунжаргал, 7б ангийн сурагч Д.Зулаа нар удааллаа.
62. СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР”-ын нөлөөллийн ажлын хүрээнд 11-р сарын 11,16 нд Аргазүйч М. Лхагважав зорилтод бүлгийн хүүхэд рүү чиглэж 2 өдрийн арга хэмжээ зохион байгуулж явууллаа.
63. 11-р сарын 11нд аймгийн БТСГ-тай хамтран монгол уламжлалт тоглоом наадгай: морь уралдуулах, шагай няслах тэмцээн зохион байгуулж "Өргөмжлөл" олимпын хорооны энгэрийн тэмдэг, 100.0 төгрөгөөр шагнаж урамшуулав.
64. 11-р сарын 16нд Аймгийн Нийтийн номын сан дээр сургалт зохион байгуулах, музей үзүүлэх, хичээлийн хэрэглэгдэхүүн, хувцас бэлэглэх зэрэг арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.Сургалтыг Сэтгэл зүйн ухааны докторант Н .Баатар “Өөртэй итгэх, сэтгэл мэдрэмжээ удирдахуй” сэдвээр явууллаа.
65. СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР-2024" аяны хүрээнд 11-р сарын 11-15-ны өдрүүдийг Маршал Ю. Цэдэнбалыг судлах 7 хоног болгосон. Энэ хугацаанд Ю.Цэдэнбалын нэрэмжит Улсын тэргүүний 1 дүгээр сургуулийн Д.Буянхүү багштай 9Г ангийн сурагчид Цэдэнбалын бага, өсвөр нас, эзэмшсэн боловсрол, монголын түүхэнд байгуулсан гавьяа, амьдарч байсан нийгэм цаг үеийн байдлын талаар судалгаа

хийж илтгэл, хэлэлцүүлэг хийлээ. Энэхүү илтгэлд хамт олноо хошуучлан оролцсон 9г ангийн сурагч Н. Болортунгалаг "Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдгээр шагнуулж , Л. Оюунгэрэл, Т. Шинэхүү, Г. Хонгорзул нар шилдэг илтгэгчээр шалгарлаа.

**Арав. Үзэсгэлэн**

**2024 онд** шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг цахим болон, бусад хэлбэрээр **155** удаа гаргаж**, 3950 хүнд 4776 ширхэг** ном хэвлэлийг сурталчилж ажилсан**.**

- Эрүүлийг хамгаалах
- Түүхийн шинжлэх ухаан
- Сэтгэл шинжлэлийн шинжлэх ухаан
- Дэлхийн эх хэлний өдөрт
- Монголын уран зохиол
- Амьдрах ухаан
- Монголын уран зохиол
- Амьдрах ухаан
- Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт
- Боловсрол соёлын шинжлэх ухаан сэдэвт
- Дэлхийн эрүүл мэндийн өдөрт
- Дэлхийн номын өдөрт
- Хэл шинжлэл
- Монголын уран зохиол
- Гадаадын уран зохиол
- Монгол бичгийн үзэсгэлэн
- Хэл шинжлэл .... гэх мэт 155 удаа

**Арван нэг . Хүний нөөцийн асуудал**

Увс аймгийн Нийтийн номын сан нь захирал, арга зүйч, мэдээллийн ажилтан- ном ажиллагч, фондын номын санч, уншлага үйлчилгээний номын санч 4, хөтөлбөрийн ажилтан, нягтлан бодогч, харуул 4, үйлчлэгч гэсэн 15 орон тоотой ажиллаж байна. Үүнээс 7 мэргэжлийн ажилтан байна.

Увс аймгийн хэмжээнд сумын Соёлын төвийн 19 номын санд 19 номын санч, 24 төрийн Ерөнхий боловсролын сургуулийн номын санд 26 номын санч ажиллаж байгаагаас 12 сум, 5 сургуулийн 17 буюу 30,9% нь мэргэжлийн номын санч байна.

Мөн Улаангом коллеж 2, Хөдөлмөрийн дээд сургуулийн 1, Эрдмийн эхлэл ахлах сургуулийн 1, номын санч ажиллаж байна. Аймгийн хэмжээнд нийт 55 номын санч ажиллаж байна

Аймгийн Нийтийн номын санд мэргэжлийн боловсон хүчин 7 ажиллаж, мэргэжлийн боловсон хүчний хангалт 100 хувьтай байна.

**Арван хоёр: Төсөв, санхүүгийн асуудал**

2024 онд улсын төсвийн санхүүжилт 418,416.1 төгрөг, орон нутгийн төсвийн санхүүжилт 109,403.5 төгрөгийн төсөвтэй нийт 527,819.6 төгрөгний төсөвтэйгээр ажиллалаа.

Байгууллагын Вэб сайт болон www.shilendans.gov.mn шилэн дансны вэб сайтад жил, улирал, сар, тухай бүрд төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах өр авлага үүссэн шийдвэрийг байршуулан ажиллалаа.

**Арван гурав: . Бусад үйл ажиллагаа**



Цагаанхайрхан сумын номын сан үндсэн фондын зохион байгуулалт



Номын техник үйл ажиллагаа хийж байна.

Ойрын фондын зохион байгуулалт

**Хилийн цэргийн 0245-р ангийн номын санд ажилласан ажлын тайлан**

Үндсэн фондын зохион байгуулалт:









Бөхмөрөн сумын Соёлын төвийн номын санд

Үндсэн фондын зохион байгуулалт:








**Зорилтод бүлгийн  хүүхдүүдэд:**



**зориулсан арга хэмжээ**

***<u>Америкийн төвд явуулсан хөтөлбөрүүд</u>***



Гүнзгий шатны англи хэл: Ахлах ангийн сурагчдад зориулсан англи хэлний сургалтыг гэрээт багш Н.Насанбат тогтмол явуулж байна. Нийт 8 удаагийн элсэлтийг 2 сарын хугацаанд хичээллүүлсэн.

**Ярианы хичээл:** 2024 оны хичээлийн жилд 7 хоногийн 3 дахь өдөр бүр анхан шатны ярианы хичээл хичээлүүлсэн. Хичээлд ЕБС-ийн сурагчид оролцож, анхан шатны ярих чадварт суралцлаа. Сургалтыг SIP хөтөлбөрийн оролцогчид чиглүүлсэн бөгөөд Америкийн төвийн ажилтнууд сургалтыг зохион байгуулахад туслаж, хамтран явуулж байлаа.

**Кино үдэш**: 2024 оны хичээлийн жилд 7 хоногийн 5 дахь өдөр бүр кино гаргаж, хөгжөөнт тоглоом явууллаа. Кино үдэшид кино үзэнгээ англи хэлний сонсгол, ярианы чадвараа хөгжүүлэх сонирхолтой ЕБС-ийн сурагчид, насанд хүрэгчид оролцлоо. Кино үдэшийг SIP хөтөлбөрийн оролцогчид чиглүүлсэн бөгөөд Америкийн төвийн ажилтнууд сургалтыг зохион байгуулахад туслаж, хамтран явуулж байлаа.





**Дунд ангийнханд зориулсан анхан шатны сургалтууд:**
8-10-р ангийнханд зориулсан англи хэлний сургалтууд тогтмол явагдлаа. Мөн бага ангийнханд зориулсан англи хэлний сургалтуудыг тогтмол явуулж байна.







"Ойрадын баатарлаг туульс хайлах ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаа"-нд Тууль, аман зохиолын 82 ширхэг ном, судар, ардын хөгжмийн зэмсэгээр үзэсгэлэн гаргаж нийтийн хүрээл болгож ажилласан.












Увсаймгийн Нийтийн номын сан нь "Үндэсний бичиг соёл, Номын өдрүүд-2024" 35










дахь Номын баярын арга хэмжээг "ИЛҮҮ ИХ УНШЪЯ" уриатайгаар тэмдэглэсэн

бөгөөд нээлтийн арга хэмжээг Гиваан баатрын талбайд хийсэн.

"**Үндэсний бичиг соёл, Номын өдрүүд-2024" 35 дахь** удаагийн номын баярын хаврын арга хэмжээнд аймгийн төвийн 6 сургуулийн номын сангууд, Улаангом коллеж, ХЦ-ын 0245-р цэргийн ангийн номын сангууд үзэсгэлэн гаргаж өргөн хүрээтэй тэмдэглэж өнгөрүүлээ

1. Номын баярын үеэр Сэдэвчилсэн номын үзэсгэлэнгүүд, Монгол бичгийн сайхан бичигтэн уралдааны бүтээлийн үзэсгэлэнгүүд гаргалаа.
   - Судар номын үзэсгэлэн

- Орон нутгийн номын үзэсгэлэн
- Түүх, Нийгмийн шинжлэх ухааны үзэсгэлэн
- Амьдрах ухааны номын үзэсгэлэн
- Бестселлер номын үзэсгэлэн
- Үндэсний бичиг үсгийн үзэсгэлэн
- Номын хавчуургын үзэсгэлэн
- Номын тэмдэглэл хөтлөх үзэсгэлэн
- Хүүхдийн уран зохиол
- Тууль, аман зохиол
- Хамгийн том ном, хамгийн жижиг ном, Гар бичмэлийн үзэсгэлэнг зохион байгууллаа.



**2. Ном уншихын ач тус-Видео контент хийлээ.**




“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024” 35 дахь удаагийн номын баярын хүрээнд ном уншихын ач тус, хүүхэд залуучуудыг номтой нөхөрлүүлэх, сургууль, анги хамт олон, байгууллага, айл өрхийн гэр номын буланг сурталчлах, сайн туршлагыг түгээх зорилгоор цуврал 3 бичлэг бүтээж, Увс аймгийн Нийтийн номын сангийн page хуудсанд байршууллаа.

Манай бичлэгийн хамгийн эхний оролцогч Б.Анхилуун нь Цогцолбор 1-р сургуулийн 3в ангийн сурагч юм. Тэр бага наснаасаа номтой нөхөрлөж, номын сангаа баяжуулж буй хамгийн залуу оролцогч. Эхэндээ үлгэр, зурагт ном унших сонирхолтой байсан бол одоо харин томоохон цувралууд уншиж байгаа гэдгээ хэлсэн. Түүний бичлэгүүд олон хүүхэд залуучуудад

таалагдсан байна.

Нийт 113 хүнд таалагдаж, 38 хүн өөрийн фейсбүүк хуудаснаа хуваалцаж, давхардсан тоогоор нийт 7200 хүнд хүрчээ.




Ном уншихын ач тусыг сурталчилсан бичлэгүүдэд маань нас, насны төлөөллөөс оролцсон юм. Бидний 2 дахь очсон айл бол Б.Ядамсүрэнгийнх байсан. Тэрээр өндөр насны тэтгэвэртээ суусан настан буурал. Залуу наснаасаа номыг шимтэн уншиж, номтой нөхөрлөсөн байна. Тэрээр ном унших нь маш олон ач тустайг үзэгч олонд сануулж, номтой нөхөрлөсөн хүний зам мөр үргэлж гэрэлтэж явдаг гэсэн юм. Түүний бичлэг нийт 71 хүнд таалагдаж, 46 хүн өөрийн фейсбүүк хуудаснаа хуваалцаж, давхардсан тоогоор 9200 хүнд хүрчээ.




Сүүлчийн зочин Д.Уранчимэг нь Цогцолбор 1-р сургуулийн монгол хэл, уран зохиолын багш. Маш олон хүүхдийг номд дурлуулж, номтой нөхөрлөхөд нь нөлөөлж үлгэрлэж ажиллаж байна. Өөрөө ч мөн сонгодог зохиолууд унших дуртай. Номын сангаа Г.Аюурзана, Л. Өлзийтөгс нарын номоор баяжуулсан. Түүний бичлэг 90 хүнд таалагдаж, 7 хүн хуваалцаж, 2600 хүн үзсэн байна.

3. “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024” 35 дахь удаагийн номын баяр, “Уншигч Увсчууд” аяны хүрээнд СТА, Завхан сумын Соёлын төвийн эрхлэгч, Дархууд овгийн Х.Цэнджавын “НАРАН ЗҮГ НУТАГ” шүлгийн номын нээлт 2024 оны 5-р сарын 22-ны өдөр аймгийн Нийтийн номын сангийн уншлагын танхимд болсон.







## 4. Харааны бэрхшээлтэй иргэдийн  дунд АХА тэмцээн зохион байгууллаа.

"Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024" арга хэмжээ, 35 дахь номын баярын хүрээнд ХБИ-ийн дунд "АХА" тэмцээн зохион байгууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь аливаа соён гэгээрүүлэх, нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцоо багатай байдаг. Номын сангийн зүгээс эдгээр иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "АХА" тэмцээнийг зохион байгуулсан. Тэмцээнд 10 хүн ирж оролцсоноос:

1-р байранд Б.Отгонжаргал шалгарч өргөмжлөл, 30 мянган төгрөг, бэлэг дурсгал, 2-р байранд Л.Анхзаяа шалгарч өргөмжлөл, 20 мянган төгрөг, бэлэг дурсгалын





зүйлээр шагнууллаа.

**Номын баярын нээлтийн арга хэмжээнд: Монголчуудын бичиг, үсгийн дурсгалууд сэдвийн дор материал цуглуулж  бэлтгэн үзэсгэлэн гаргалаа.**

Эрдэмтдийн үзэж байгаагаар Монгол угсаатан нь монгол хэлэнд нийцүүлсэн маш олон бичиг үсэг зохион аж амьдралдаа хэрэглэж байсан. Эдгээрээс хамгийн түгээмэл, нийтэд дэлгэрч байсан, монгол хүн бүрийн заавал мэдэж байх ёстой 14 бичиг үсгийн мэдээлэл бэлтгэж, үзэсгэлэнд дэлгэн Номын баяраар дэлгэн тавилаа. Мөн хамгийн том ном, хамгийн жижиг номоор үзэсгэлэн гаргалаа.







"Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024" Номын баяр арга хэмжээний хүрээнд  Цогцолбор
1-р сургуулийн 6г ангийн сурагчдад Сан хөмрөгийн номын санч Д.Уранчимэг "Ном унших ач тус" сэдвээр тойм яриа хийлээ.





"Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024" 35 дахь удаагийн номын баярын хүрээнд  ЕБ-ийн 3-р сургуулийн О.Янжиндулам багштай 3б ангийн хамт олонд "Тед шиг л байя" номоор "Үлгэрээс үлгэрлэе" уриатай "Чанга уншлага" зохион байгууллаа.

Улсын тэргүүний Солонго 4-р цэцэрлэгийн Бэлтгэл 1, 2-р бүлгийн хүүхдүүдэд Чанга уншлага хийлээ. Бэлтгэл 1-р бүлгийн хүүхдүүдэд “Дуулгавартай байцгаая”, “Зааны тугал”, “Гайхамшигт цасан хүн” номуудаар, Бэлтгэл 2-р бүлгийн хүүхдүүдэд “Улаан малгайт Пэти”, “Гал сөнөөгч” номуудыг тус тус уншиж өгч,





хамтран ярилцлаа.








5. "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024" арга хэмжээний хүрээнд ЕБС-ийн 7, 8-р ангийн сурагчдын дунд монгол бичгийн хичээлийн мэдлэг бататгах зорилготойгоор “Алтан хонх” тэмцээнийг зохион явууллаа. Тэмцээнд 30 хүүхэд оролцсоноос ЕБ 5-р сургуулийн 7б ангийн сурагч Б.Анхзаяа тэргүүлж өргөмжлөл 50 мянган төгрөг, 3-р сургуулийн 7б ангийн сурагч Б.Ариунжаргал удаалж өргөмжлөл, 30 мянган төгрөг, 7б ангийн сурагч Д.Зулаа 3-р байр эзлэж, өргөмжлөл, 20 мянган төгрөгөөр тус тус шагнууллаа.








Төрийн албан хаагчдын монгол бичиг сурах идэвхийг өрнүүлэх, уншлагын хурд болон бичгийн чадварыг дээшлүүлэх зорилгоор “Монгол бичиг”-ийн уралдааныг зохион байгууллаа.






“Номын санч" мэргэжлийн ач холбогдол, тухайн мэргэжлийн онцлог давуу тал сэдвээр ЕБ-ын ахлах ангийн сурагчдад яриа танилцуулга хийлээ.




Зөөврийн үйлчилгээ:








**Номын хэлэлцүүлэг:**








## Зохиолч уншигчдын уулзалт:





## Цахим мэдээлэл:









## ОЛОН НИЙТЭД ЗОРИУЛСАН ХӨТӨЛБӨРҮҮД






**SIP  хөтөлбөр амжилттай хэрэгжлээ**

**Гадаад багштай англи хэлний сургалт**

Энхтайвны корпусын сайн дурын ажилтан Даниел Америкийн төвд ажиллалаа.

Сайн дурын ажилтан Даниел дадлагажигч сурагчидтай хамтран англи хэлний ярианы сургалтууд болон Movie night хөтөлбөрийг 10 өдрийн турш зохион байгууллаа.







Олон улсын брайль өдөр тохион Америкийн төвд "Бүгдээрээ хамтдаа" арга хэмжээг зохион байгууллаа.







**Номын сангийн тохижилт**




Америкийн төвийн тохижилт

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл Урлагийн газраас “ Монгол гэр уламжлалт урлал, зан үйл” өвийг сурталчлах түгээн дэлгэрүүлэх арга хэмжээнд зориулсан монгол гэр оёх арга хэмжээнд номын сангийн ажилтан оролцлоо.




Байгууллагын урд талбайг  туслах ажилтнууд зүлэгжүүлж, ногоон орчин бий болголоо.






Номын сан, Музей, Ойрад театр гурвын дунд байрлах 0,5 га газрын хог хаягдлыг хамт олны хүчээр ачиж зайлуулахад 3 машин хог гарсан. Улмаар тус талбайд мод тарьж, орос сортын үрээр зүлэг тарьсан нь хилэн ногоон өнгөтэй, сайхан ургалаа.

Ард иргэдийг номтой нөхөрлүүлж, номын сайн нөхөр болгоход орчин нөхцөл хамгаас чухал юм. Уншигчид байгальд ойрхон байж, зүлгэн дээр сууж ном унших боломж бүрдүүллээ.




**Америкийн номын сангуудаас туршлага судаллаа**

Увс аймгийн Нийтийн номын сангийн захирал Б.Батхүү 2024 оны 1-р сарын 20-31-ний өдрүүдэд АНУ-ын нийслэл Вашингтон ДС хотын болон Тулса, Канзас

хотын номын сангуудтай танилцах аялал хийгээд ирсэн. “Номын сангаар дамжуулан АНУ-ыг судлах нь” Олон улсын зочдын манлайллын хөтөлбөрт Америкийн төвүүдийн номын сангийн удирдлагууд хамрагдсан бөгөөд нийтдээ 8 хүн өөрсдийнхөө унааны зардлаа дааж Америк яваад ирсэн. Америкийн номын сангуудаар зочилсон талаараа захирал Б.Батхүү аян замын тэмдэглэл бичиж, үндэсний өдөр тутмын хэвлэл болох “Өнөөдөр” сонины 2024 оны 4-р сарын 18-ны дугаар болон “Увсын өнгө” сонины 2024 оны 3-р сарын 28-ны өдрийн дугаарт тус тус хэвлүүлсэн. Мөн ажилчиддаа болон Америкийн төвөөр үйлчлүүлсэн хүүхэд залууст Америкийн номын сангууд хэрхэн ажилладаг талаар мэдээлэл хийсэн.
























Увс аймгийн Төв номын сан
Нийтэлсэн: Lhagwasuren Altantsetseg
· 1d ·

"СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР-2024 АЯН"
ДӨРВӨД АЯЛГА
Миний хамгийн үнэнч, надаас хэзээ ч үл урвах
Цорын ганц нөхөр минь -эх хэл
Миний зэвсэг болж, дайсны өөдөөс зоригтой босгодог... **Цааш үзэх**




"СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР-2024" АЯН
САН ХӨМРӨГИЙН БАЯЖИЛТАНД НОМ ХАНДИВЛАЛАА.




10-р сарын 18 ·
ӨНӨӨДӨР МОНГОЛЫН ЭМЧ НАРЫН VII ИХ ХУРАЛ ТӨРИЙН ОРДОНОО БОЛЖ БАЙНА.
2024.10.18
Хурлаар "Эрүүл мэндийн салбарын бодлого, шинэчлэл"-ийн талаар илтгэл сонсож, "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ", "Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлого, нийгмийн баталгаа, сургалт, инновац" зэрэг сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлж, нэгдсэн дүгнэлт, зөвлөмж гаргана.
Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Их хурлыг нээж үг хэллээ. Тэр бээр цар тахлын үед амь биеэ үл хайрлан, цаг наргүй ажиллаж, ... **Цааш үзэх**



"СОЁЛЫН БҮТЭЭЛ САР-2024" Аяны хүрээнд нийтийн уншлагыг дэмжих,идэвхжүүлэх,уншигчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор номын санч Л.Алтанцэцэг,Америкийн Соёл мэдээллийн төвийн номын санч Б. Мөнхшүр нар Увс аймгийн Цагдаагийн газрын бие бүрэлдэхүүний өглөөний ярианы үеэр нь очиж Заябандида Намхайцамцын нэрэмжит Увс аймгийн Нийтийн номын сангийн зорилго,зорилт, үйл ажиллагааны танилцуулагыг өгч ажиллаа. Мөн энэ үеэр Амьдрах ухаан,Монголын уран зохиолын номоор үзэсгэлэн гаргаж, гарын авлага боршуур тараалаа.
Хамтран ажилласан Цагдаагийн газрын Мөрдөн байцаах алба болон бусад хүмүүст баярлалаа.
Номын цагаан буян мөнхөд ивээх болтугай.







Увс аймгийн Төв номын сан
Нийтэлсэн: Lhagwasuren Altantsetseg
· 11-р сарын 11 өдрийн 16:49 цаг ·

#НОМЫН ҮЗЭСГЭЛЭН"
"СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР-2024" аяны хүрээнд Уншлагын танхим нь энэ долоо хоногийн онцлох түүхэн хүн Төр нийгмийн нэрт зүтгэлтэн, БНМАУ-ын баатар, Хөдөлмөрийн баатар,Маршал Ю.Цэдэнбалтай холбоотой номын үзэсгэлэнгүүдийг дэлгэж уншигч та бүхэндээ өргөн барьж байна.
Та бүхэн манай номын сангаар зочлон үзэсгэлэн үзэж сонирхон, үйлчлүүлээрэй.




Увс аймгийн Төв номын сан
Нийтэлсэн: Lhagwasuren Altantsetseg
· 11-р сарын 16 өдрийн 12:12 цаг ·

"СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР-2024 АЯН"
УРТЫН ДУУНЫ ҮҮСЭЛ ХӨГЖИЛ











13-р цэцэрлэг.



















1. Харааны бэрхшээлтэй иргэдийн дунд "АХА" тэмцээнийг зохион байгууллаа.





1. Ногоон хот - Бидний оролцоо"





1. **Үндэсний баяр наадам**




2. **Өрөө тасалгааны цэвэрлэгээ болон, засвар, цэцэгжүүлэлт**







1. **Мэтгэлцээний тэмцээн**








2. **Намрын номын баярын хүрээнд хийгдсэн харааны бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгуулсан өдөрлөг.**





## ХОВД АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН
## 2024 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН

МУСГЗ.М.Баянзулын нэрэмжит Нийтийн номын сан нь Төрөөс соёлын талаар баримтлах бодлогыг соёлын үйл ажиллагаанд иргэн, гэр бүл, байгууллагын оролцоог нэмэгдүүлж, монгол хүнийг бага наснаас нь хүмүүнлэг, оюунлаг, соёл, уламжлалаа дээдэлдэг иргэн болгон төлөвшүүлэх зорилго зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулан ажиллаж байна.

**Бидний алсын хараа:** Уламжлалт болон мэдээллийн технологид суурилан, нийгмийг мэдлэг, мэдээллээр хангахад бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ манлайлагч байна.

**Зорилго:** Орон нутгийн хүн амын боловсрол, соёл, мэдээлэл, чөлөөт цагийн эрэлт хэрэгцээнд нийцсэн номын сан ном зүйн үйлчилгээг үзүүлж, бие хүнийг бүтээлчээр хөгжүүлэхэд оршино. Соёлын бодлого, байгууллагын зорилго зорилтын хүрээнд номын сангийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах “Оюунтүлхүүр” багц хөтөлбөр боловсруулж, аймгийн Засаг даргын 2021-2025 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт оруулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

**ОЮУНТҮЛХҮҮР ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД:**

Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024” хавар намрын номын баярыг нэгдсэн удирдамжийн дагуу хөтөлбөр гарган зохион байгуулж явууллаа.

### Нэг. Ерөнхий зүйл

Үндэслэл: Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль, “Алсын хараа- 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлиг, Аймгийн “Монгол хэл, бичиг”, “Оюунтүлхүүр” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь үндэслэл болно.

Арга хэмжээний ерөнхий зохион байгуулагчаар Ховд аймгийн ЗДТГ, Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, Нийтийн номын сан

Хаврын номын баярыг 28 төрлийн 2 өдрийн арга хэмжээ зохион байгуулсан. Намрын номын баярыг 2 агуулгын хүрээнд 35 үйл ажиллагааг зохион байгууллаа. Номын баярын 2 удаагийн үйл ажиллагаанд оролцогчид 15000 гаруй иргэд хамрагдсан байна.. Номын баярын үйл ажиллагааны цахим мэдээлэл хүрсэн хүний тоо 53419.

Арга хэмжээний үеэр хүндэтгэл үзүүлэх, шагнал гардуулсан тухай мэдээлэл:

“Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн”-ээр шалгарсан сурагчдын болон “Номын сайн нөхөр анги” уралдааны шагнал гардуулах ёслол боллоо.

“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024” хаврын арга хэмжээнд аймгийн хэмжээнд 40 гаруй төрийн байгууллагын 1400 гаруй албан хаагчид ирж үзсэн нь иргэдийн оролцоо, идэвх өмнөх жилүүдээс ахисан үзүүлэлт болов.

Энэ удаагийн номын баярын онцлог нь мэдээлэл, сургалт сурталчилгаа, үзүүлэн таниулах ажил, уншлагыг дэмжих арга хэмжээ, номын худалдаа, уншигч зохиолчдын уулзалт, судалгаа гэсэн үндсэн 6 агуулгатайгаар зохион байгуулан ажилласан.

**Хоёр. Зохион байгуулсан үйл ажиллагаа:**

Аймаг орон нутагт болон номын сангийн үйлчлүүлэгчдийн дунд соёл олон нийт мэдээллийн 63 нэр төрлийн үйл ажиллагааг зохион байгуулсан.

**2.1 Мэдээлэл, сургалт сурталчилгааны ажил**

Номын сангийн тухай хуулийн сурталчилгаа, хэлэлцүүлэг

Номын сангийн тухай хууль болон уншигчдын эрх үүргийн талаарх мэдээллийг уншлагын танхимаар үйлчлүүлсэн уншигчдад болон талбайн үйл ажиллагаан дээр сурталчилж ажиллаа. Танхимаар 104, цахимаар хүрсэн хүний тоо 1100

"Уншаад урагшлахуй" ном уншлагыг сурталчлах, сэдэлжүүлэх: Ахлах, дунд ангийн сурагчдыг чөлөөт цагаараа идэвхтэй ном уншлагад хамруулах, урлан бүтээх авьяасыг нь сэдэлжүүлэх зорилготой оролцууллаа.

Тус арга хэмжээг багийн зохион байгуулалтаар зохион байгууллаа.

Дээрх арга хэмжээнд 7 сургуулийн 1700 гаруй сурагчид оролцсон.

"Номын өргөөний ид шид" лекц танилцуулга.

Ахлах, дунд ангийн сурагчдын дунд үйл ажиллагааг зохион байгууллаа

Тус арга хэмжээнд 3 сургуулийн 155 хүүхэд хамрагдсан.

"Ардын үлгэрийн амтыг мэдэрье" чанга уншлага.

Үйл ажилагаанд Прогресс, ЕБ-ын 3, 6-р сургуулийн 3-4-р анги, 3, 5, 14 дугаар цэцэрлэгийн суралцагчид хамрагдлаа.

Тус арга хэмжээнд 470 хүүхэд хамрагдсан.

"Мэргэжил сурталчилах"-өдөрлөгийг ахлах, дунд ангийн сурагчдад номын санч-мэдээллийн ажилтны мэргэжлийн онцлогийг таниулж, мэргэжил сонголтод нь дэмжлэг үзүүлэн онол, дадлагыг хослуулан мэргэжлийн ажил дээр томилон ажилласан маш их үр дүнтэй боллоо. нийт 47 сурагч хамрагдлаа.

Уншигч зохиолчдын уулзалтыг зохион байгуулж явууллаа. Уулзалтад орон нутгийн эрдэмтэн судлаач МУИС-ийн баруун бүсийн сургуулийн багш Бямбадорж, МЗЭ-ийн гишүүн зохиолч, яруу найрагч, орчуулагч А.Оюунчимэг, МЗЭ-ийн гишүүн яруу найрагч Г.Бямбаа, яруу найрагч Г.Хүлэгбоорчи нар оролцож ЕБС-ийн сурагчдад үнэтэй сургамж зөвлөгөө өгч, харилцан ярилцсан сайхан уулзалт боллоо. 49 хүн хамрагдлаа.

"Хос бичигтэн Ховдчууд" ажлын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудын хаягжилтыг хос бичгээр бичсэнийг нийтэд сурталчилж уриаллаа. Нийт 18 байгууллага оролцсон байна.

"Урилгат уншлага"-ыг тэргүүний уншигчид, багш, зохиолчдыг урьж уншлага зохион байгууллаа. Нийт 5 уншлагын танхимаар 18 анги буюу 500 гаруй хүн хамрагдсан байна.

"Номын гэгээ контент" ном уншлагыг сурталчлан түгээн дэлгэрүүлэх зорилгоор номын сангийн дэргэдэх "Оюуны өртөө" клубын сурагчид контент хийж цахимаар сурталчиллаа. Нийт хандалт 600

"Book battle" номын мэтгэлцээнд ЦАЦ сургууль, 1-р сургуулийн 11д, Прогресс сургуулийн 11-р анги, 7 дугаар сургуулийн 11-р ангийн сурагчид Монголын болон гадаадын уран зохиолоор цэц мэргэнээ уралдуулж мэтгэлцлээ. 45 сурагч оролцсон.

"Book flashmob" 2 өдрийн арга хэмжээний нээлтэд Прогресс сургууль, 7 дугаар сургуулийн сурагчид оролцлоо. Оролцогчдын тоо 45

Уран зохиолын үдэшлэгийг ЕБС-ийн ахлах ангийн сурагчид орон нутгийн зохиолч уран бүтээлчдийн дунд зохион байгуулж явууллаа.

“Номын садан” шилдэг сургууль шалгаруулах уралдааныг зохион байгуулж, Цаст-Алтай цогцолбор сургууль, 7 дугаар сургууль, Прогресс сургуулийн хамт олон шалгарлаа.

Номын клуб, ном сонирхогчдын уулзалтыг зохион байгуулж, олон нийт, сургуулийн сурагчдыг номтой нөхөрлүүлэх талаар болон клубын гишүүдийн хүрээг өргөжүүлж, үйл ажиллагааг сайжруулах талаар нээлттэй хэлэлцүүлгийг хийлээ. 42 сурагч хамрагдлаа.

Шинэ номын худалдаа. Арга хэмжээнд Титэм, Ном хөлцийт ХХК болон хувиараа бизнес эрхлэгчид шинэ номоо хямдралтай үнээр худалдаж оролцогчдын талархыг хүлээсэн үйл ажиллагаа боллоо.

Зохиолчдын гарын үсэгтэй номын худалдааг зохион байгуулж, МЗЭ-ийн гишүүн зохиолч, яруу найрагч, орчуулагч А.Оюунчимэгийн 100 гаруй бүтээлийн үзэсгэлэн худалдаа дэлгэгдлээ.

<u>“ Номын хандив өргөсөн, номын санд хөрөнгө оруулсан хувь хүн, албан байгууллагыг урамшуулах, алдаршуулах</u>

Аймгийн ИТХ, ЕБ-ын 6 дугаар сургуулийн багш Сайнжаргал, МУИС-н салбар сургуулийн номын сан, Иргэн Оюун, баруун бүсийн утга зохиолын чуулганд ирсэн МУСГЗ зохиолч Б.Норов, Увс аймгийн МЗЭ-ийн гишүүн яруу найрагч Г.Оюун-Эрдэнэ, Увс аймгийн зохиолч Ц.Цэнджав нараас 100 гаруй ширхэг ном хандивлалаа.

<u>Ховор хуучин номын үзэсгэлэн зохион байгуулах</u>

Нийтийн номын сангийн үндсэн фондоос, Хөгжил Политехник коллеж, МУИС-ийн салбар сургуулийн номын сан болон хувь хүний ховор хуучин номын 65 төрлийн номоор үзэсгэлэн гаргаж сурталчиллаа.

<u>“Бийрээ нийлье, ургаа уудалъя!” үндэсний бичиг, угийн бичгийн сургалт</u>

Энэ удаагийн сургалтыг ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд угийн бичгийг хөтлөх аргачлал болон үр удамдаа угийн бичгээ өвлүүлэн үлдээх сургалтыг 2 удаа зохион байгууллаа. Хамрагдсан хүний тоо 132

<u>“Соёлын өртөөчилсөн аялал” номын сан, музей, театртай танилцах аялал</u>

Бага ангийн сурагчдыг номын сангийн үйл ажиллагаатай танилцуулах аялалыг зохион байгууллаа. СӨБ-н болон ЕБС-ийн 1-2-р дугаар ангийн 120 сурагч хамрагдлаа.

<u>Номын санч уншигчдад зориулсан цахим сургалт</u>

Сумдын соёлын төвийн номын санчидтай цахим сургалт явууллаа.

**4.2 Үзүүлэн таниулах ажил**

<u>Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн</u>

Уншлага үйлчилгээний 7 тасаг танхимын шинэ болон сэдэвчилсэн 500 гаруй номын үзэсгэлэн гаргаж сурталчиллаа. Цахим үзэсгэлэнг 273 хүн үзсэн байна. Онцлог ном Ганжуур, Данжуурын дахин хэвлэлтийн номуудыг хүмүүс их сонирхож байв.

<u>Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжсэн төрөл бүрийн материалаар хийсэн ном, баринтаг, хавчуурга болон бусад зүйлсийн үзэсгэлэнг ЕБС-ийн номын санч нар гаргаж суралчиллаа.</u>

Нийтийн номын сангаас Жангар туулиар танин мэдэхүйн хөлөгт тоглоом хийж худалдааллаа.

Тэргүүний уншигч хүүхдүүдийн бүтээл, номын тэмдэглэлийн үзэсгэлэн

